



БАЙГАЛЬ ОРЧИН АЯЛАЛ
ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ



МУИС, ГАЗАРЗҮЙН ТЭНХИМ

КОВИД-19-ИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЛБАРТ УЧРУУЛЖ БУЙ ЭДИЙН ЗАСГИЙН НӨЛӨӨЛЛИЙН ТАЛААРХ СУДАЛГААНЫ ТАЙЛАН

(Тур оператор байгууллагуудын хүрээнд)



УЛААНБААТАР ХОТ

2021 ОН

СУДАЛГААНЫ БАГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Багийн ахлагч:

Д.Амартүвшин /PhD/

*Монгол Улсын Их Сургууль, Шинжлэх Ухааны Сургууль,
Газарзүйн Тэнхимийн багш, судлаач*

Гишүүд:

Б.Ариунтуул /MBA/

*Монгол Улсын Засгийн Газрын Хэрэг Эрхлэх Газар, Удирдлагын
Академийн Мэдээлэл технологийн тасгийн эрхлэгч*

Б.Зандан /MBA, MA/

Шинжлэх Ухааны Академи, Олон Улс Судлалын Хүрээлэнгийн судлаач

М.Лхагвасүрэн /BSc/,

Судалгааны туслах ажилтан

© Судалгааг Байгаль Орчин Аялал Жуулчлалын Яамны санаачилга, санхүүжилтээр гүйцэтгэв. Судалгааг цааш түгээх, ашиглах бол судлаачид болон эх сурвалжийг дурдна уу.

АГУУЛГА

1. УДИРТГАЛ	4
1.1 Судалгааны үндэслэл	4
1.2 Судалгааны зорилго	6
1.3 Судалгааны арга зүй.....	6
1.4 Судалгааны хамрах хүрээ	6
2. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРААС АВЧ ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ БОДЛОГО АРГА ХЭМЖЭЭ	8
2.1 Хууль, эрх зүйн орчны шийдвэрүүд /эхний шийдвэрүүдээс эхлээд дүр журам гарсан хүртэл/ бодлого, арга хэмжээнүүд.....	8
3. ЦАР ТАХАЛ КОВИД-19-ИЙН ОЛОН УЛСЫН НӨХЦӨЛ БАЙДАЛ	12
3.1 Цар тахал “Ковид-19” дэлхий дахинд.....	12
3.2 Цар тахлын эсрэг улс орнуудын хэрэгжүүлж буй бодлого, арга хэмжээ.....	14
3.3 Олон улсын эдийн засгийн байдал 2020-2023	18
4. МОНГОЛ УЛСЫН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЛБАРЫН НӨХЦӨЛ БАЙДАЛ	19
4.1 Цар тахал “Ковид-19” Монголд.....	19
4.2 Цар тахлын эсрэг Монгол улсын хэрэгжүүлж буй бодлого, арга хэмжээний аялал жуулчлалын салбарт үзүүлэх нөлөөллийн шинжилгээ	21
4.3 Цар тахал ба дотоодын аялал жуулчлалын төлөв байдал	22
5. СУДАЛГААНЫ ҮР ДҮН: ЦАР ТАХЛЫН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЛБАРТ УЧРУУЛЖ БУЙ ЭДИЙН ЗАСГИЙН НӨЛӨӨЛӨЛ	23
5.1 Инбаунд, аутбаунд, дотоодын зах зээлийн тойм	23
5.2 Голлох зах зээл	24
6. ҮНДЭСНИЙ ЭДИЙН ЗАСАГТ ОРУУЛЖ БУЙ ТУР ОПЕРАТОР ЭДИЙН ЗАСГИЙН НӨЛӨӨ	26
6.1 Борлуулалтын орлого ба дам үр ашиг.....	26
6.2 Ажил эрхлэлт	28
6.3 Цар тахлын үеийн хүндрэл, бэрхшээл.....	29
6.4 Байгууллагын зүгээс цар тахлыг даван туулж буй аргууд.....	33
6.5 Засгийн газрын байгууллагуудад олгосон дэмжлэгийн ач холбогдол	35
7. ЦАР ТАХЛЫН ДАРАА АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫГ СЭРГЭЭХЭД ШААРДЛАГАТАЙ ЗҮЙЛС	37
7.1	37
Засгийн газраас авах бодлого, арга хэмжээ үр нөлөөний шинжилгээ.....	37
7.2 Аялал жуулчлалын салбарыг сэргээхэд хэрэгжүүлэх бодлого, арга хэмжээний үзүүлэх нөлөөллийн сценарио шинжилгээ.....	39
7.3 Тур операторуудын аялал захиалгын төлөв (2021-2023)	44
7.4 Засгийн газраас хийх боломжит ажлууд	45
8. СУДАЛГААНЫ ДҮГНЭЛТ	49
Эх сурвалж	52


1. УДИРТГАЛ

1.1 Судалгааны үндэслэл

Аялал жуулчлалын салбарт цар тахлаас үүдэж буй эдийн засгийн нөлөөг судлах зайлшгүй шаардлага буй болжээ. Учир нь Монгол улсад Ковид-19 цар тахлын нөлөөгөөр 2020 онд олон улсын аялал жуулчлал зогсч, 605 сая гаруй ам долларын орлого тасалдахад хүрлээ. Энэхүү орлогыг бүрдүүлэхэд гол үүрэгтэй оролцдог тур оператор байгууллагуудын нөхцөл хүндэрч байгаа ч ямар хүндрэл, хэчнээн хэмжээний мөнгөн алдагдалтай байгаа нь тодорхойгүй хэвээр байна. МАЖХ-д 2020 оны байдлаар тур операторын үйл ажиллагаа явуулахаар бүртгэгдсэн 570 байгууллага байна (МАЖХ, 2020). Эдгээр байгууллагууд экспортын орлого оруулж, эдийн засагт чухал хувь нэмэр оруулдаг ч цар тахлын үед ямар хүндрэл бэрхшээл тулгарч байгаа нь судлагдаж орхигджээ. Мөн засгийн газраас цар тахлын хүндрэлийг даван туулахаар хэрэгжүүлж буй арга хэмжээнүүд хэр үр дүнтэй байгаа хийгээд цаашид ямар арга хэмжээ авах нь чухал байгаа талаарх тур оператор байгууллагуудын удирдлагуудын саналыг сонсох нь чухал байна. Нөхцөл байдлыг судлахгүйгээр бодлогын шийдвэр гаргах нь бодлого, шийдвэрийн ач холбогдол, үр нөлөөг бууруулах, төсвийн үргүй зардлыг нэмэгдүүлэх эрсдэлтэй юм.

Монгол улсад 2019 оны байдлаар аялал жуулчлалын салбарт 88,700 гаруй хүн ажиллаж, 605.5 сая америк долларын орлого оруулсан нь ДНБ-ний 6.48 хувийг бүрдүүлж байна (ҮСХ, 2020). Аялал жуулчлалын салбар нь олон бүрдэл хэсэгтэй бөгөөд тур оператор, тур агент, зочлох үйлчилгээ, үзвэр, тээвэр, худалдаа үйлчилгээ гэх дэд хэсгүүдийг багтаасан, нэг нэгэнтэйгээ харилцаа нягт уялдаа бүхий салбар юм. Амралт, чөлөөт цаг аялал жуулчлалын салбарын бүрдэл хэсгүүдийг Зураг 1-д харууллаа. Эдгээрээс тур оператор байгууллагууд зохион байгуулалттай аялал жуулчлалыг зорих газарт авчирч, гадаад валютын орлогыг оруулдаг бол дотоодын болон олон улсын бие даан аялагчид мөн бусад үйлчилгээний байгууллагуудаар үйлчлүүлж тус салбарын эдийн засгийн үр өгөөжийг буй болгож байна. Уг судалгаанд тур оператор байгууллагуудыг хамруулах гол үндэслэл нь тур операторууд аялал жуулчлалын дэд салбаруудтай хамгийн нягт, олон чиглэлээр ажилладаг тул салбарыг төлөөлөх боломж хамгийн их, мөн уялдаа холбоо бүхий бусад салбаруудад энэ төрлийн судалгаа аль хэдийн хийгдсэн (тухайлбал зочлох үйлчилгээний салбарын судалгаа), зарим салбарууд албан ёсны статистик бүртгэлээр илрүүлэх боломжтой (тухайлбал тээврийн салбар) юм.

Зураг 1. Аялал жуулчлалын салбарын бүрдэл



Аялал жуулчлалын салбарын нөхцөл байдлын бусад судалгаа

Цар тахлаас улбаалан хувийн хэвшилд ямар хүндрэл бэрхшээл учирч байгааг Монголын Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим (МХАҮТ), Зочид буудлын холбоо зэрэг байгууллагууд судалсан хэдий ч тур оператор байгууллагад ямар хүндрэл бэрхшээл учирч байгаа нь судлагдажгүй орхигджээ.

МХАҮТ-ийн судалгаа хэдийгээр хувийн хэвшлийг бүхэлд нь хамруулсан ч уг судалгаанд аялал жуулчлалын 41 байгууллага хамрагдсан (МХАҮТ, 2020). Тэдгээрээс тур оператор болон аялал жуулчлалын бусад салбарын байгууллага ямар хувьтай хамрагдсан эсэх нь тодорхойгүй байна.

Үүний дээр, зочлох үйлчилгээний салбарын судалгаа хийгдсэн хэдий ч мөн л тур операторын байгууллагууд судалгаанд хамрагдажгүй орхигдсон байна. Иймд, Монголын Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим болон Аялал жуулчлалын хөгжлийн төвөөс цар тахлын үеийн бизнесийн орчны судалгааг гүйцэтгэсэн хэдий ч эдгээр судалгаанд аялал жуулчлалын салбарыг төлөөлөх чадварыг хангаж чадахааргүй цөөн тооны байгууллага хамрагдсан тул судалгааны үр дүнгээр Аялал жуулчлалын салбарын онцлог, нөхцөл байдлыг бүрэн илрүүлж чадахгүй юм. Ковид-19 цар тахлын нөлөө олон улсын аялал жуулчлалд хэрхэн нөлөөлж байгаа судалгаа олон улсад хийгдсэн байгаа хэдий ч Монгол улсын аялал жуулчлалын салбарт ямар нөлөө үзүүлж байгааг тоймлож судлаагүй байгаа нь тус судалгааны ач холбогдлыг илтгэж байна. НҮБ-ын ДАЖБ болон Япон, Өмнөд Солонгос, Өмнөд Африк, Шинэ Зеланд улсуудад хийгдсэн судалгааг тоймлон судалж, уг судалгааны арга зүйн суурь жишиг болгон ашиглав.

Ковид-19 олон улсын болоод дотоодын аялал жуулчлалын эдийн засагт нөлөөлсөнөөр аймаг бүрт харилцан адилгүй үр дагавар гарч байгаа дүр зураг ажиглагдлаа. Мөн аялал жуулчлалын дэд салбаруудын ажил эрхлэлт цөөрч, цар тахлын дараа тус салбар мэргэшсэн хүний нөөц, мэргэшсэн байгууллагын дутагдалд орж болзошгүй байна. Иймд аялал жуулчлалын салбарт Ковид-19-ийн нөлөөгөөр ямар хүндрэл бэрхшээл тулгарч байгааг судалж, засгийн газраас нотолгоонд суурилсан шийдвэр гаргах нь юу юунаас илүү тулгамдаж байна.

1.2 Судалгааны зорилго

Цар тахал Ковид-19-с Монголын аялал жуулчлалын салбарт учруулж буй эдийн засгийн нөлөөллийг судалж, тулгамдаж буй асуудлуудыг илрүүлэх, хамаарлыг шинжлэн асуудлыг шийдвэрлэх үндсийг тодорхой болгох зорилготой. Энэ хүрээнд аялал жуулчлалын тур оператор байгууллагуудын удирдах албан хаагчдыг судалгаанд хамруулж, цар тахлын үеийн бизнесийн нөхцөл байдал, тэдний өөрсдийн болоод засгийн газраас авч хэрэгжүүлж буй арга хэмжээг хэрхэн үнэлж байгаа болон цаашид аялал жуулчлалыг салбарыг хэрхэн сэргээх талаарх саналыг судлахыг зорилоо. Энэ хүрээнд дараах зорилтуудыг дэвшүүллээ. Үүнд:

- Монгол улсын дотоодын болоод олон улсын аялал жуулчлалын зах зээлд Ковид-19 цар тахлаас учруулж буй эдийн засгийн нөлөөг тооцоолох;
- Улмаар аялал жуулчлалын салбарын бүрдэл хэсэг болох инбаунд, аутбаунд тур операторуудад нөлөөлж буй нөлөөллийн цар хэмжээг тодруулах;
- Тус салбарын бизнес эрхлэгчид, удирдах ажилтнууд, ажиллагсад засгийн газраас бодлогын ямар шийдэл хүлээж байгааг тоймлох юм.

1.3 Судалгааны арга зүй


Харьцангуй богино хугацаанд цар хэмжээ өргөнтэй судалгаа гүйцэтгэхийн тулд тоон судалгааг асуумж судалгааны аргаар гүйцэтгэв. Төсвийн хязгаарлагдмал боломжийг үндэслэн аялал жуулчлалын дэд салбаруудаас зөвхөн инбаунд, аутбаунд, дотоодын зэх зээлд ажилладаг тур оператор байгууллагуудыг судалгаанд хамрууллаа. Судалгааны өгөгдлийг цуглуулахдаа цахим анкет бөглүүлэх аргаар анхдагч өгөгдөл, макро эдийн засгийн статистик тоон үзүүлэлтийг цуглуулах замаар хоёрдогч өгөгдлийг бүрдүүлсэн ба өгөгдлийн шинжилгээ хийхдээ зарим үзүүлэлтийн тархалт, нэг хүчин зүйлсийн шинжилгээ, хоёр хүчин зүйлсийн шинжилгээ, олон хүчин зүйлсийн хамаарлын шинжилгээ, орц-гарцын загварын шинжилгээ (Input-Output Table Analysis), хүчин зүйлсийн зүй тогтлын хоорондын хамаарлыг тодорхойлох регрессийн шинжилгээ болон сценари шинжилгээгээр тооцоолов.

1.4 Судалгааны хамрах хүрээ

Монголын тур операторуудын цар тахлын өмнөх үеийн нөхцөл байдал хэрхэн өөрчлөгдөж, цар тахлын үе ямар хүндрэл бэрхшээлтэй тулгарч байгааг судлан, ирээдүйд бодлогын ямар шийдэл, дэмжлэг чухал болохыг доорх хүснэгтэд харуулсан сэдвүүдийн хүрээнд гүйцэтгэв. Асуулга судалгааг 2020.12.26-2020.12.27-ны өдрүүдэд Сурвэй Манки хэрэглүүрийг ашиглан цуглуулж, шинжилгээ хийлээ. Судалгаанд нийт 252 байгууллага хамрагдсан байна. Давхардсан тоогоор уг судалгаанд хамрагдагсдын дийлэнх нь удирдах албан тушаалтнууд байсан бөгөөд 56 хувь нь компанийн үүсгэн байгуулагч, 13 хувь нь хувь эзэмшигч, 30 хувь нь захирал, 29 хувь нь гүйцэтгэх захирлын албан

хашиж буй хүмүүс байлаа. Харин менежерийн түвшний ажилтан 19 хувь, ажилтан 8 хувийг бүрдүүлж байв. Судалгааг захиалагч талын хүсэлтээр зарим шаардлагагүй үр дүнгийн хэсгийг (тухайлбал аялал жуулчлалын төрөл хэлбэр, голлох орнууд г.м) тайланд тусгасангүй.

Зураг 2. Судалгаанд хамрагдагсдын тур операторуудыг төлөөлсөн албан тушаалтан (n=119)



Хүснэгт 1. Судалгааны хүрээ


Ковидын өмнө	Ковидын үед	Ковидын дараа
Голлох зах зээл (улс)	Орлого хэдэн хувь буурсан	Аяллын төрөл
Голлох сегмент (Аяллын төрөл)	Байнгын ажлын байраа хэчнээн тоогоор цөөрүүлсэн	Засгийн газраас хүсэх дэмжлэг
Орлого	Авч хэрэгжүүлж буй арга хэмжээ	Цахим виз
Жуулчдын тоо	Ковидын үеийн үйл ажиллагааны төлөвлөгөө	Дотоодын аялагчдын ваучер
Ажлын байрны тоо (Удирдах, Менежер, Гүйцэтгэх)	Ажлын байр хадгалж чадаж байгаа эсэх	Эрүүл мэндийн баталгаа
Татвар	Ажлын байраа хадгалж байгаа аргууд	Вакцинжуулалт
Түрээс	Өөр бизнесийн салбарт хөрвөж байгаа эсэх	Зээлийн хүүгийн татаас
Цалингийн фонт	Төрийн бодлого, шийдвэр ямар хүндрэл учруулж байна	Хөнгөлөлттэй зээл
Даатгал	Засгийн газрын тусламж дэмжлэгт хамрагдсан эсэх	Дижитал маркетингийн татаас
Зээл	Дотоодын аяллын зах зээлд ажилласан эсэх	
Бусад эрхэлдэг бизнес	Салбарын яам, харьяа байгууллагын ажлын уялдаа холбоо	
Эрсдэлийн сан	Сургалт	
	Цахим үйл ажиллагаа	

2. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРААС АВЧ ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ БОДЛОГО АРГА ХЭМЖЭЭ

2.1 Хууль, эрх зүйн орчны шийдвэрүүд /эхний шийдвэрүүдээс эхлээд дүр журам гарсан хүртэл/ бодлого, арга хэмжээнүүд

Монгол улсад Ковид-19 тахлын анхны тохиолдол 2020 оны 3 дугаар сард бүртгэгдэж, Засгийн газар өндөржүүлсэн бэлэн байдал зарласан. 11 дүгээр сарын 11-ны өдөр анх удаа дотоодын халдвар бүртгэгдэн, 12 сарын 14-ний өдөр хүртэл хатуу хөл хорио улс даяар тогтоов. 2021 оны 3 дугаар сарын 27-ны өдрийн байдлаар нийт 6693 тохиолдол бүртгэгдэж, эдгэрсэн 4237, нас барсан 6, эмчлүүлж байгаа 2427 байна. 2021 оны 2 дугаар сарын 23-ны өдөр Ковид-19 цар тахлаас сэргийлэх анхны вакциныг хүлээн авсан бөгөөд 3 дугаар сарын 27-ны өдрийн байдлаар нийт 269,400 хүн вакцинжуулалтад хамрагджээ¹. 2020 оны 3 дугаар сараас 2021 оны 3 дугаар сар хүртэлх хугацаанд Засгийн газраас хэрэгжүүлсэн арга хэмжээнүүдийг тоймлоё.

Зураг 3. Цар тахлын үед Монгол улсын Засгийн газраас гаргасан гол шийдвэрүүд



- **2020 оны 1 дүгээр сар**

Сургууль, цэцэрлэгийг 1 дүгээр сарын 27 – 3 дугаар сарын 2-н хүртэл хаах шийдвэрийг Улсын Онцгой комисс гаргав².

- **2020 оны 2 дугаар сар**

2020 оны 2 дугаар сарын 1-ний өдрөөс 2020 оны 3 дугаар сарын 2 хүртэлх хугацаанд БНХАУ-тай хиллэдэг агаар, төмөр зам, автозамын бүх боомтоор БНХАУ-ын иргэд болон тус улсын нутаг дэвсгэрээр дамжин ирэх бусад улсын иргэдийг хилээр нэвтрүүлэхийг хориглов. Мөн хугацаанд Монгол Улсын иргэд БНХАУ-д зорчихыг хориглов³.

- **2020 оны 3 дугаар сар**

¹ Эрүүл мэндийн яам (2021). "2021 оны 03 дугаар сарын 27 өдрийн нөхцөл байдлын мэдээ." <https://covid19.mohs.mn/p/cat/post/57/>.

² News.mn (2020). "УОК: Цэцэрлэг, сургуулийг гуравдугаар сарын 2-н хүртэл хаана." <https://news.mn/r/2252974/>.

³ Ikon.mn (2020). "Гуравдугаар сарын 2-ныг дуустал Монгол Улсын иргэдийг урд хөрш рүү явахыг хориглолоо." <https://ikon.mn/n/1s93>.

Монгол улсад Ковидын халдварын анхны тохиолдол Франц улсын иргэнээс илэрч 3 дугаар сарын 10-16-ны өдрүүдэд Улаанбаатар хот, аймаг сумаас гарах болон орох, хот хоорондын зорчигч тээвэр, орон нутгийн хуваарьт нислэг, галт тэрэг, хувийн тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг зогсоов.

Засгийн газар эмзэг бүлгүүдийг хамгаалж, эдийн засгийг дэмжихэд зорилгоор зарим импортын хүнсний бараа бүтээгдэхүүн, эм эмнэлгийн хэрэгслүүдийг татвараас чөлөөлж, хүүхдийн мөнгө, ажилгүйдлийн тэтгэмжийг нэмэгдүүлж, 2020 оны 9 дүгээр сарыг дуустал аж ахуйн нэгжүүдийг нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлж, Хөгжлийн банкнаас жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд зээлийн батлан даалт гарган, ноолууран бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдэд олгох хөнгөлөлттэй зээлийн хэмжээг нэмэгдүүлэв.

Монголбанкнаас бодлогын хүүг 100 суурь пунктээр 10 хувь болгон бууруулж, банкуудын төгрөгийн заавал байлгах нөөцийг 8.5 хувь болгон бууруулж, бодлогын хүүгийн коридорыг ± 1 хувь болгон нарийсгах болсноо мэдэгдсэн бөгөөд заавал байлгах нөөцийн шалгуурын өөрчлөлт нь банкны системд 324 тэрбум төгрөг (ДНБ-ий 0.8 хувь) нэмэлт хөрөнгийг чөлөөлөв⁴.

Хятадтай хилээ хаасны дараа экспорт зогссон байсан бөгөөд Хятад Улс руу 3 дугаар сарын 15-ны өдрөөс нүүрсний экспортоо сэргээв.

- **2020 оны 4 дүгээр сар**

“Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль” 2020 оны 04 дүгээр сарын 29-нд баталсан. Тус хуулиар Коронавирусын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах талаар Улсын Их Хурал, Засгийн газар, Улсын онцгой комисс, Төв банк, арилжааны банк болон бусад төрийн байгууллагаас авч хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлсон.

Мөн өдөр “Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлын үед иргэдийн эрүүл мэнд, орлогыг хамгаалах, ажлын байрыг хадгалах, эдийн засгийг идэвхжүүлэх багц арга хэмжээний тухай” улсын их хурлын тогтоол”, аж ахуйн нэгжийн орлогын албан татвараас хөнгөлөх, чөлөөлөх тухай, **Татварын алданги, торгуулиас чөлөөлөх тухай, Хувь хүний орлогын албан татвараас чөлөөлөх тухай, Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай, Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай, Нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлөх, ажилгүйдлийн даатгалын сангаас дэмжлэг үзүүлэх тухай, Нийгмийн даатгалын шимтгэл төлөгчийг торгох шийтгэл, алдангиас чөлөөлөх тухай, Олон улсын гэрээний тухай хуульд нэмэлт оруулах тухай** хуулиудыг тус тус батлав.

⁴ Эрдэнэчимэг, Э. and М. Мөнхдулам (2020). "Цар тахлын үед Монгол Улсын Засгийн газраас эдийн засгаа сэргээх, мөнгө болон санхүүгийн бодлогын хүрээнд авсан арга хэмжээ." <https://www.kas.de/mn/web/mongolei/einzeltitel/-/content/t-rijn-bajguulal-sudlal-setg-l-02>.

“Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлын үед санхүү, эдийн засгийн тогтвортой байдлыг хангах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, төрийн үйлчилгээнд цахим шилжилт хийх арга хэмжээний тухай” улсын их хурлын тогтоолыг батлав.

Засгийн газраас зарим бүтээгдэхүүнийг татвараас чөлөөлөх шийдвэрийг батлан гаргасан. 4 дүгээр сарын 13-ны өдөр Монголбанкнаас гаргасан мэдэгдэлд бодлогын хүүг 100 суурь пунктээр 9 хувь хүртэл бууруулж, одоо байгаа хэрэглээний зээлийн үндсэн болон хүүгийн төлбөрөө 12 дугаар сар хүртэл хойшлуулах боломжийг ард иргэдэд олгов.

- **2020 оны 5 дугаар сар**

2020 оны 5 дугаар сарын 6-ны өдөр нийгмийн эмзэг бүлгийг эдийн засгийн хямралаас хамгаалах хөтөлбөрийн хоёр дахь багц арга хэмжээг хэрэгжүүлэн, ДНБ-ий 2 хувьтай тэнцэх хэмжээний санхүүгийн туслалцаа үзүүлэх төсөв батлав. Үүнд хүүхдийн мөнгөн тэтгэмжийг цаашид нэмэгдүүлэх, хүнсний талон олгох, өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй, өрх толгойлсон эцэг эхчүүд болоод бүтэн болон хагас өнчин хүүхдүүдэд олгох нийгмийн халамжийн тэтгэмжийг нэмэгдүүлэв⁵.

- **2020 оны 8 дугаар сар**

Засгийн газраас хүүхдийн мөнгийг 100,000 төгрөг хэвээр үлдээх, аж ахуйн нэгжийг орлогын албан татвараас чөлөөлөх, түрээсийн орлогын албан татвараас чөлөөлөх, импортын зарим бараа бүтээгдэхүүнийг гаалийн болон нэмүү өртгийн албан татвараас чөлөөлөх арга хэмжээнүүдийг хэвээр үлдээнэ гэж зарлав. Дараах арга хэмжээнд өөрчлөлт оруулсан: хүнсний талоны хүрэлцээг нэмэгдүүлэх, нийгмийн халамжийн тэтгэмжийг нэмэгдүүлэх, нийгмийн даатгалын шимтгэлийг бууруулах зэрэг арга хэмжээ хэрэгжүүлсэн бөгөөд эдгээрт дотоодын нийт бүтээгдэхүүний 7.5 орчим хувьтай тэнцэх төсвийг УИХ 2020 оны 8 дугаар сарын 28-ний өдөр батлан гаргав.

Монголбанк 7 дугаар сард дуусах байсан санхүүгийн хөнгөлөлтийн арга хэмжээг түр сунгах болсноо зарлав⁶.

- **2020 оны 9 дүгээр сар**

9 дүгээр сарын 14-ний өдөр Монголбанк бодлогын хүүг 100 нэгжээр бууруулж 8 хувь болгов.

- **2021 оны 11 дүгээр сар**

Ковид-19 дотооддоо голомтлон халдварлаж, Гамшгаас хамгаалах тухай хуульд заасны дагуу стратегийн гол 15 салбарын байгууллагуудыг (хүнсний дэлгүүр, хүнсний үйлдвэр, шатахуун түгээх станц, нефть хангамжийн байгууллага,

⁵ Мөн тэнд.

⁶ Мөн тэнд.

эмнэлэг, эмийн сан, усан хангамж буюу худаг, эрчим хүч, дулааны цахилгаан станц, хэвлэл мэдээлэл, харилцаа холбооны байгууллага, буяны ажил болон хот хоорондын хүнсний тээвэр) хэвийн горимд ажиллуулан бусад байгууллагуудын үйл ажиллагааг хаах буюу алсын зайнаас эрхлэх шийдвэрийг гаргасан.

Монголбанк бодлогын хүүг 200 нэгжээр бууруулж 6 хувь болгож, төгрөгийн заавал байлгах нөөцийн шаардлагыг 6 хувь болгон бууруулж, бусад арга хэмжээг 2021 оны 7 дугаар сарын 1 хүртэл үргэлжлүүлэн сунгасан. Бодлогын хүүг 2 нэгж хувиар бууруулж 6 хувьд хүргэх; эргэн төлөлт нь доголдсон хэрэглээний зээлд бүтцийн өөрчлөлт хийж, хугацааг сунгах арга хэмжээг 2021 оны 7 дугаар сарын 1-ний өдрийг хүртэл үргэлжлүүлэн хэрэгжүүлэх; жижиг дунд үйлдвэр, уул уурхай бус экспортыг дэмжихэд зориулсан урт хугацаат дахин санхүүжилтийн хэрэгслийг нэвтрүүлэх багц шийдвэрийг гаргасан.

- **2021 оны 12 дугаар сар**

Халдвар бүртгэгдсэн бүс нутгуудад 3 тэрбум төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг үзүүлэх, татварын торгуулиас чөлөөлөх, Улаанбаатар хотын гэр хорооллын иргэдэд шахмал түлшийг 50 хувийн үнээр олгох болсон.

2020 оны 12 дугаар сарын 13-ны өдөр Засгийн газар корона вирусийн үеэр цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээг танилцууллаа. Үүнд: 12 дугаар сарын 1-ний өдрөөс ирэх оны 7 дугаар сарын 1 хүртэл төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, уул уурхайн олборлолт, боловсруулах чиглэлийн ААН, бөөний болон жижиглэнгийн худалдаа эрхлэгч, согтууруулах ундаа, тамхи үйлдвэрлэгч зэрэг 9 байгууллагаас бусад ААН-үүдийн цахилгаан, дулаан, дулааны уур, усан хангамж, хогны төлбөрийг тэглэсэн, 100 хүртэл м.кв талбайтай сууцтай айл өрхүүдийн дулааны төлбөрийг тэглэсэн бөгөөд 100 м.кв-аас дээш талбайтай сууцтай айл өрхүүдийн хувьд үлдсэн төлбөрийг өөрсдөө төлөхөөр зааж өгсөн. Улаанбаатар хотын гэр хорооллын иргэдэд шахмал түлшийг 25 хувийн үнээр олгох болсон.

2020 оны IV улиралд Төв банк репо арилжаагаар 230 тэрбум төгрөгийн санхүүжилтийг арилжааны банкуудаар дамжуулан жижиг дунд үйлдвэр, уул уурхайн бус экспортыг дэмжих зорилгоор олгохдоо бодлогын хүү (6.0) дээр банкны ажиллагааны зардал, эрсдэл тооцсон 4.5% нэмэгдлээс илүүгүй нийт 10.5% жилийн хүүтэй байхаар тогтоов. Үүний хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор ЖДҮ-д олгох зээлийн дээд хэмжээнд 300,0 сая төг, уул уурхайн бус экспортын компанид 1.0 тэрбумаар хязгаар тавьсан ба хоёроос багагүй жилийн хугацаатай, эхний 6 сар үндсэн зээлээс чөлөөлөх нөхцөлтэй юм.

2021 оны 1 дүгээр сар

Жижиг дунд үйлдвэр, уул уурхайн бус экспортыг дэмжих жилийн 10.5% хүүтэй зээлийг 2021 онд улирал бүр хэмжээг нь тодорхойлж, нэмэгдүүлэн олгох бодлогыг Монголбанк хэрэгжүүлэх ба 2021 оны 1 дүгээр улиралд 250.0 тэрбумыг батлав.

2021 оны 2 дугаар сар

Тогтвортой байдлын зөвлөл КОВИД-19-ийн цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр 2021 онд төсвөөс 1.7 их наяд төгрөг зарцуулагдахаар байгааг мэдээлэв⁷.

3. ЦАР ТАХАЛ КОВИД-19-ИЙН ОЛОН УЛСЫН НӨХЦӨЛ БАЙДАЛ

3.1 Цар тахал “Ковид-19” дэлхий дахинд

Ковид-19 нь амьтнаас хүнд халдварласан шинэ коронавирусээр үүсгэгдсэн агаар дуслын замаар дамждаг халдварт өвчин⁸ бөгөөд 2019 оны 12 сарын сүүлээр БНХАУ-д гарч, 2020 оны 1 сард олон улсад хурдацтай тархан, 3 сард ДЭМБ-аас цар тахал хэмээн зарласан билээ. 2020 оны 12 сарын 31-ний байдлаар дэлхий даяар нийт 81,475,053 тохиолдол бүртгэгдэж, 1,798,050 хүн нас барсан гэж ДЭМБ мэдээлжээ⁹. Ковид-19 цар тахал нь хүний амь нас, эрүүл мэндэд заналхийлэхээс гадна эдийн засгийн томоохон хүндрэлүүдийг учруулж байна.

Дэлхийн улс орнууд Ковид-19 цар тахалтай тэмцэж, хариу арга хэмжээ авч байгааг нь харьцуулахад өөр өөр байгаа бөгөөд эрдэмтэд, хэвлэл мэдээллийнхэн хамгийн сайн ба хамгийн муу жишээнүүдийг нэрлэж байна. ‘TIME’ сэтгүүлд 2020 оны 6-р сард халдвар авсан тохиолдол, сая хүнд ногдох нас баралтын тоог шалгуур болгож Ковидод хамгийн сайн хариу үйлдэл үзүүлсэн улсуудыг онцлохдоо Тайвань, Сингапур, Шинэ Зеланд, Австрали, Канад, Герман, Исланд, Арабын Нэгдсэн Эмират, Грек, Аргентин зэрэг улсуудыг нэрлэжээ.

Цар тахлын эхэн үед халдварт тохиолдлын тоо болон нас баралтын тоог чухалчилж байсан бол цаг хугацаа өнгөрөхөд эдгээр тооноос гадна улс орны эрүүл мэндийн систем, санхүүгийн хариу үйлдэл, олон нийтэд мэдээлэл өгч байгаа байдал, амьдрал хэвийн үргэлжилж байгаа байдал зэрэг бусад хүчин зүйлсийг мөн авч судалсан байна. Жишээлбэл, Фишер нарын судлаачид 2020 оны 9-р сард долоон шалгуур гаргаж ирсэн бөгөөд үүнд¹⁰:

1. Тохиолдлуудыг эрт илрүүлж, тархалтыг зогсоох чадвар. Үүнд эрүүл мэндийн систем сайн байж, оношлогоо хүртээмжтэй байх;
2. Халдвар авсан иргэдийг тусгаарлаж, хавьтлуудыг хөл хорионд байлгах чадвар;
3. Хавьтлуудыг шуурхай илрүүлж хаана байгааг тогтоох чадвар;
4. Нийгмийн эрүүл мэндийн хуулиудтай байж, олон нийт нь үүнийг хүлээн зөвшөөрч, дагадаг байх;
5. Иргэдийн орлогыг хамгаалах. Энэ нь нийгэм эдийн засгийн тогтвортой байдлыг хангаж, иргэд үндэсний бодлогыг дагах хүчин зүйл болно. Хүнс

⁷ Ikon.mn (2021). "Цар тахлын нөлөөг бууруулахад улсын төсвөөс 2021 онд 1.7 их наяд төгрөг зарцуулагдахаар байна." <https://ikon.mn/n/2480>.

⁸ Эрүүл Мэндийн Яам, "Ковид-19 Коронавирус Гэж Юу Вэ?," Эрүүл Мэндийн Яам,, <https://www.mohs.mn/v/232>.

⁹ WHO, "Who Coronavirus Disease (Covid-19) Dashboard," WHO,, <https://covid19.who.int/>.

¹⁰ Dale Fisher, Yik Ying Teo, and David Nabarro, "Assessing National Performance in Response to Covid-19," *The Lancet* 396, no. 10252 (2020).

болон эмийн нийлүүлэлт хангалттай, хүртээмжтэй байснаар иргэд дүрэм журам сахих нэг чухал хүчин зүйл болно.

6. Эмзэг бүлгийнхнийг хамгаалж дэмжих. Энэ нь төр засгийн хийх нэг чухал ажил, учир нь эмзэг бүлгийнхэн амьдралын хэв маягаас шалтгаалан халдварт илүү их өртөх магадлалтай байдаг.
7. Харилцаа холбоо, манлайлал. Төр засгийн ил тод, шударга, ойлгомжтой харилцаа иргэдэд итгэл төрүүлж, цар тахлыг тогтоон барихад сайн нөлөө үзүүлнэ.

'Foreign Policy' сэтгүүл "Ковидод хариу үйлдэл үзүүлсэн индекс" гаргаж дэлхийн улс орнуудыг жагсаажээ. Шалгуурт:

1. Ковидын өмнөх нөхцөл байдал:

- Өр, ДНБ-ий харьцаа;
- Нярайн нас баралтын хэмжээ;
- Мянган хүнд ногдох эмнэлгийн орны тоо;
- Эрх, тэгш бус байдлыг хэмжих Жини коэффициент;
- Эрүүл мэндийн үйлчилгээний чанар, хүртээмжтэй байдал.

2. Ковид гарсны дараа төр засгийн шийдвэрүүд, үүнд олон нийтэд хандсан удирдамж:

- Гэрт байх шийдвэр;
- Сургууль хаах шийдвэр;
- Олон нийтийн цугларлыг хязгаарласан байдал;
- Олон нийтийн арга хэмжээг цуцалсан байдал;
- Шинжилгээ өгөх бодлого, 1000 хүнд ногдох шинжилгээний тоо;
- Нэг хүнд ногдох түргэн тусламжийн үйлчилгээний зардал;
- Аяллыг хязгаарлах бодлого;
- Хавьтлыг илрүүлэх чадвар.

3. Санхүүгийн хариу үйлдэл:

- Эдийн засгийн дэмжлэгийн багц, ДНБ-д эзлэх хувиар;
- Орлогын дэмжлэг;
- Өр төлбөрийг хойшлуулах.

4. Олон нийтэд мэдээлэл өгөх байдал:

- Удирдагчдын буруу мэдээлэл өгөх тохиолдол;
- Хэвлэлийн эрх чөлөөний хязгаарлалт, цензур.

5. Улс орны КОВИД-19-ийн одоогийн болон өнгөрсөн үеийн байдал:

- 1 сая хүнд ногдох нас баралтын түвшин;
- 1 саяд ногдох хэргийн хувь хэмжээ.

“Foreign Policy” сэтгүүлийн 10-р сарын “Ковид-19-д хариу үйлдэл үзүүлсэн индекс”-ийн жагсаалтаар Шинэ Зеланд, Япон, Кени, Австрали, Гана зэрэг улсуудыг тэргүүлжээ¹¹.

Блүүмбергийн “Ковидыг сөрөх зэрэглэлээр” улс орнуудыг сар бүр жагсааж байгаа бөгөөд ингэхдээ 10 шалгуураар хэмжиж байна. Үүнд халдварын тохиолдлын тоо, нас баралтын тоо, оношлох чадвар, улсын эрүүл мэндийн систем, халдвараас шалтгаалан эдийн засгийг царцаах хөл хорио тогтоох, хүссэн газраа явах боломж, вакцины хүртээмж зэрэг орсон ажээ. Тус жагсаалтад 53 орныг хамруулсан бөгөөд 1-рт Шинэ Зеланд, дараа нь Тайвань, Австрали, Норвеги, Сингапур, Финлянд, Япон, БНСУ, БНХАУ, Дани, Канад, Вьетнам зэрэг улсууд тус тус дараалан жагссан байна. Цар тахлын үед авторитар дэглэмүүд илүү амжилттай ажиллах болов уу гэсэн таамаг байсан боловч ардчилсан дэглэмтэй улс орнууд дээгүүр орсныг тэмдэглээд, ард түмэн төр засагтаа итгэх итгэлтэй бол заавал хүчээр хөл хорио тогтоогоогүй ч Ковид-19-ийн эсрэг амжилттай ажиллаж байна¹² гэсэн дүгнэлтийг хийжээ.

Улс орнуудыг Ковидтой тэмцэж байгаагаар нь харьцуулах шалгууруудаас харахад зөвхөн цар тахал дэгдэх үеийн халдварын тоо, нас баралтын тооноос гадна дунд болон урт хугацаанд цар тахлаас сэргийлэх чадамжийг чухалчилж авч үзсэн байна. Дээр дурдсан жагсаалтуудад дээгүүр орж Ковидтой амжилттай тэмцэж буй улсуудын хэрэгжүүлсэн арга хэмжээг авч үзье.

3.2 Цар тахлын эсрэг улс орнуудын хэрэгжүүлж буй бодлого, арга хэмжээ

Олон улсад Ковидтой тэмцэхээр хэрэгжүүлж байгаа стратегийг 1) бууруулах, 2) дарах, 3) устгах гэж гурав хувааж авч үзжээ. Бэйкер нарын судлаачид бууруулах, дарах стратегиуд нь цар тахал тархах явцыг хязгаарлах, оргил үеийг сулруулах үүднээс сургуулиудыг хаах зэрэг арга хэмжээ авахад чиглэгддэг гэж тодорхойлжээ. Харин устгах стратеги нь халдвар дамжуулалтын гинжин хэлхээсийг таслахад чиглэсэн хяналтын арга хэмжээнүүдийг эрс нэмэгдүүлдэг. Хойд Америк, Европын өндөр хөгжилтэй улсууд ихэвчлэн бууруулах стратеги баримталсан бол БНХАУ, Тайвань, Хонг Конг, БНСУ зэрэг Азийн орнууд устгах стратеги баримтлан амжилтыг олсон байна гэж үзжээ. Шинэ Зеланд, Австрали улсууд эхлээд халдварт өвчинтэй тэмцэх үндэсний стратегийг баримталсан боловч амжилттай жишээнээс суралцах хугацаа гарсан тул стратегийг өөрчлөн, устгах стратегийг баримталж эхэлсэн гэжээ¹³.

Тэд Ковидыг устгасанд тооцох нөхцөлийг дараах байдлаар тодорхойлжээ:

- Шинээр оношлогдсон SARS-CoV-2 вирусийн халдвар олон нийтэд дамжихгүй байх - тогтоосон бүс нутагт тодорхой хугацаанд буюу (тухайн байршилд хамгийн сүүлд мэдэгдсэн тохиолдол тусгаарлагдсанаас хойш 28 хоногийн дараа батлагдсан тохиолдолд шинээр илрэхгүй байх)

¹¹ Foreign Policy, "The Covid-19 Global Response Index," Foreign Policy, <https://globalresponseindex.foreignpolicy.com/>.

¹² Rachel Chang, Jinshan Hong, and Kevin Varley, "The Covid Resilience Ranking," Bloomberg,, <https://www.bloomberg.com/graphics/covid-resilience-ranking/>.

¹³ Michael G Baker, Nick Wilson, and Tony Blakely, "Elimination Could Be the Optimal Response Strategy for Covid-19 and Other Emerging Pandemic Diseases," *BMJ* 371 (2020).

- Өндөр чадамжтай тандалтын системтэй байх
- Зарим тохиолдлыг, жишээлбэл хилийн боомтоор орж ирсэн, хяналтад байгаа халдварын гэх мэт тохиолдлуудыг хүлээн зөвшөөрөх гэх мэт.

Хэвлэл мэдээллийн байгууллагууд болон судлаачдын амжилттай ажилласан гэж үзсэн Тайвань, Шинэ Зеландын жишээнээс авч үзье.

Тайвань

Тайвань нь БНХАУ-тай хил залгаа боловч халдварын тохиолдол болон нас барагсдын тоо бага байгаа (23.7 сая хүн амтай, 2021 оны 1-р сарын байдлаар 815 хүн халдвартай, 7 хүн нас барсан байна¹⁴) нь олон улсад сайшаагдан, Ковидын эсрэг амжилттай арга хэмжээ авсан гэгдэж байна. Тайванийг халдварт өвчин гарахад хэрэгжүүлэх сайн төлөвлөгөөтэй байсан бөгөөд хэрэгжүүлэхдээ ч сайн хэрэгжүүлсэн гэж сайшааж байгаа юм байна. Цар тахал эхлэнгүүт Тайвань хилээ хааж, маск экспортлохыг хориглов¹⁵. Мөн маск үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх арга хэмжээ авч, цэргүүдийг татан оролцуулав. Оршин суугчдын гар утасны симээр хавьтлыг илрүүлж, бүх мэдээллийг эмнэлгүүд болон эмийн сангийнхантай нэгдсэн системээр хуваалцаж байсан бөгөөд¹⁶ хөл хорионд байгаа хүмүүс дүрэм зөрчсөн эсэхийг шалгаж байв. Гаднаас ирсэн иргэдээ 14 хоног хөл хорионд байлгаж 'geofencing' буюу дижитал хашаанаас гарахад дохиолол ажилладаг технологи ашиглажээ. Олон нийтийн газруудад гар ариутгах төхөөрөмжүүд байршуулж, халуун шалгаж, маск зүүхийг шаардаж, зүүгээгүй бол өндөр торгууль ногдуулж байв. Төр засгаас нь маск хаана үлдэгдэлтэй байгааг харж болдог программ хөгжүүлж газрын зурагтай холбосон аж. Өдөр бүр олон нийтэд мэдээлэл хийж байжээ. Эрүүл мэндийн нэгдсэн цахим системтэй тул БНХАУ руу аялсан иргэд болон амьсгалын замын өвчтэй хүмүүсийг шинжилгээнд хамруулсан байна¹⁷.

Шинэ Зеланд

Шинэ Зеланд нь нягтаршил бага, 5 сая гаруй хүн амтай гэдгээрээ Монголтой төстэй бөгөөд Ковидыг амжилттай зогсоосноороо олон улсад үнэлэгдээд байна. Шинэ Зеланд цар тахлыг эхэн үед нь устгаж авах стратеги баримталсан бөгөөд цар тахал эхлэнгүүт иргэн биш хүмүүст хилээ хаажээ. Энэ улс 5.1 сая хүн амтайгаас 2021 оны 1-р сарын 4-ний байдлаар 2181 тохиолдол, 25 нас баралттай бөгөөд дахиж шинэ тохиолдол бүртгэгдээгүй байна. Шинэ Зеланд нь хөл хорио тогтоож, хавьталуудыг дижитал арга замаар илрүүлж, халдвар авах магадлалтай хүмүүсийг шинжилгээнд шуурхай хамруулжээ¹⁸. Ингэхдээ өдөрт 10,000 хүнийг шинжилж байсан бөгөөд халдвар илэрсэн тохиолдолд хариуцсан ажилчид бүх хавьталуудад мэдэгдэж ажиллаж байв.

¹⁴ Taiwan Centers for Disease Control, "Covid-19 Infection," <https://www.cdc.gov.tw/En>.

¹⁵ Ian Bremmer, "The Best Global Responses to Covid-19 Pandemic," TIME, <https://time.com/5851633/best-global-responses-covid-19/>.

¹⁶ C. Jason Wang, Chun Y. Ng, and Robert H. Brook, "Response to Covid-19 in Taiwan: Big Data Analytics, New Technology, and Proactive Testing," *JAMA* 323, no. 14 (2020).

¹⁷ Christina Farr and Michelle Gao, "How Taiwan Beat the Coronavirus," CNBC, <https://www.cnbc.com/2020/07/15/how-taiwan-beat-the-coronavirus.html>.

¹⁸ Alexis Robert, "Lessons from New Zealand's Covid-19 Outbreak Response," *The Lancet Public Health*, [https://www.thelancet.com/journals/lanpub/article/PIIS2468-2667\(20\)30237-1/fulltext](https://www.thelancet.com/journals/lanpub/article/PIIS2468-2667(20)30237-1/fulltext).

Кени

Кени нь 45 сая хүн амтай Африкийн томоохон улс бөгөөд 2021 оны 1-р сарын 3-ны байдлаар 96,802 халдварын тохиолдол, 1,685 нас баралттай байна. Хэдийгээр статистик үзүүлэлт нь өмнөх хоёр улстай харьцуулахад өндөр боловч олон улсад Ковидын сайн жишээ гэж үнэлэгдсэн бөгөөд хөгжиж буй улс тул хийсэн ажлуудаас нь авч үзье. Кени үйлдвэрүүдээ маск үйлдвэрлэлийн чиглэлээр шинэчилж тоноглоод, маскийг хэдэн саяар нь үйлдвэрлэж эхэлсэн байна.¹⁹ 2020 оны 3 дугаар сараас Кенийн засгийн газраас бага орлоготой иргэдэд, аж ахуйн нэгжүүдэд татварын хөнгөлөлт, НӨАТ-ийн хөнгөлөлт олгож, мөн ахмадууд, эмзэг бүлгийнхэнд тэтгэмж олгож эхэлжээ. Газарзүйн байршил илрүүлэх системийг шийдвэрлэхэд ашиглаж, эмзэг бөгөөд халдвартай иргэдийн байршил, түргэн тусламжийн байршил, нөөц хязгаарлагдмал байгаа байршлуудыг тодруулж байв. Цар тахлын тархалт цаг хугацаа өнгөрөхөд хэрхэн өөрчлөгдөж байгааг мөн цахимаар ажиглаж байжээ²⁰.

Ковидын эсрэг амжилттай арга хэмжээ авч байгаа улсуудын жишээнээс харахад дараах арга хэмжээнүүдийг авсан байна:

1. Төр засаг нь тодорхой төлөвлөгөөтэй, түүнийгээ дагаж, олон нийтэд нэгдсэн мэдээлэл өгч чадсан.
2. Хилээр орж ирэх зорчигчдыг эрт хязгаарлаж эхэлсэн.
3. Хавьтлуудыг үр дүнтэй илрүүлсэн.
4. Мэдээллийн технологийг шинэлэг байдлаар ашигласан улсууд. Жишээлбэл, Гана улсад шинжилгээний сорьцыг лабораториуд руу дроноор хүргэж байсан гэнэ²¹
5. Шинжилгээг иргэдэд үнэгүй бөгөөд хүрэлцээтэй байдлаар шуурхай хийж байсан.
6. Хөл хорио тогтоосон ба зарим нь дүрэм зөрчих эсэхийг цахим газрын зураг ашиглан хянаж байсан.
7. Цар тахал дэгдэхээс өмнө эрүүл мэндийн тогтолцоо сайтай байсан.
8. Эдийн засгаа дэмжих мөнгө төсөвтөө суулгаж, иргэд болон бизнесүүдэд тэтгэмж, зээл олгож, зээлийг хойшлуулах зэргээр иргэдийн амьжиргаа болон ажлын байр хадгалахыг хичээсэн.

¹⁹ Brookings, "Learning from the Best: Evaluating Africa's Covid-19 Responses," <https://www.brookings.edu/blog/africa-in-focus/2020/07/08/learning-from-the-best-evaluating-africas-covid-19-responses/>.

²⁰ Matthew Tyce, "Kenya's Response to Covid-19," Effective States and Inclusive Development, <https://www.effective-states.org/kenyas-response-to-covid-19/>.

²¹ Brookings.

Хүснэгт 2. Засгийн газрууд аялал жуулчлалын салбараа дэмжиж ажиллаж байгаа байдал

	Улс	Аялал жуулчлалыг дэмжиж байгаа ажлууд
1	Шинэ Зеланд	<ul style="list-style-type: none"> - Стратегийн ач холбогдолтой аялал жуулчлалын өв хөрөнгийг хамгаалахад бизнесүүдэд болон орон нутгийн аялал жуулчлалын байгууллагуудад жилийн 3хувь хүүтэй 5 жилийн хугацаатай зээл олгосон. - 26 инбаунд тур операторуудад орлогынх нь хэмжээнээс шалтгаалан 3хувь хүүтэй 5 жилийн хугацаатай зээл олгосон. - Маори буюу Шинэ Зеландын уугуул иргэдийн бизнесүүдэд санхүүжилт олгосон. - Аялал жуулчлалын чанарыг хангадаг 'Qualmark' болон орон нутгийн зөвлөх байгууллагуудаар дамжуулан аялал жуулчлалын компаниудад үнэгүй зөвлөгөө өгч байна. - Компаниуд дижитал стратеги боловсруулахад нь дэмжлэг болох сургалт хийж, зөвлөгөө өгч, цахимжих тал дээр нь анхаарсан байна. - Дотоодын аялал жуулчлал нь орон нутгийн арга хэмжээнүүд дээр суурилдаг тул тэдгээрийг дэмжихэд \$50 сая төсөвлөж, орон нутгийн аялал жуулчлалын байгууллагуудаар дамжуулан олгож байна. - Аялал жуулчлалын компаниудыг тусгай хамгаалалтын газруудын хураамжаас чөлөөлсөн байна. - Төр, хувийн хэвшлийн хамтарсан баг байгуулж, аялал жуулчлалын ирээдүйг хэлэлцэж, бодлого боловсруулахад оролцох болжээ²².
2	БНСУ	<ul style="list-style-type: none"> - Аялал жуулчлалын компаниудад бага (1хувь) орчим хүүтэй зээл олгож - Энгийн хүүтэй зээлийн эх үүсвэрийг нэмэгдүүлсэн, зээлийн эргэн төлөлтийн хугацааг хойшлуулсан. - Үл хөдлөх хөрөнгийн татварыг бууруулсан - Зочид буудалд төлсөн мөнгөнөөс татвар буцааж авах хугацааг сунгасан - Ажлын байрыг хадгалж үлдэхийн тулд 6 сарын цалинтай чөлөө олгох болж, төсвөөс 90 хувийг даасан, үргэлжлүүлээд 3 сар цалингүй чөлөө олгох хугацаанд 410 ам доллар олгосон. - Дотоодын аялал жуулчлалыг дэмжсэн: аялал жуулчлалын ваучеруудыг тараасан, компаниудад ажилтнуудаа аялуулахыг дэмжиж 25хувийг даасан. - Гар ариутгагч, маск тараасан, Ковид илэрсэн аялал жуулчлалын бизнесүүдэд ариутгал хийж өгсөн²³
3	Кени	<p>Богино хугацаанд:</p> <p>Аялал жуулчлалын салбарын ажилтнуудыг шинэ нөхцөлд дасан зохицсон протокол мөрдүүлэх, сургалт явуулах, Аялал жуулчлалын бүтээгдэхүүнийг аудио, видео, зураг, график хэлбэрт оруулах.</p> <p>Дунд хугацаанд:</p> <p>Дотоодын, бүсийн, олон улсын аялал жуулчлалыг нээх, Санхүүгийн дэмжлэг үзүүлэх, татвар хураамжийг эргэж харах, хүү царцаах, Дижитал маркетингийн стратегийг сайжруулах.</p> <p>Урт хугацаанд:</p> <p>Аялал жуулчлалын гинжин хэлхээсийн бүх хэсгүүдээр нэгдсэн журмаар хариу үйлдэл үзүүлэх, Хямралыг даван туулах сургалтуудыг зохион байгуулах, Ажилчдыг мотивацлах, чадваржуулах сургалтууд зохион байгуулах Салбарын нэгдсэн системийг боловсруулах,</p>

²² Innovation and Employment Ministry of Business, "Tourism Recovery," <https://www.mbie.govt.nz/immigration-and-tourism/tourism/tourism-recovery/>.

²³ Sports and Tourism Ministry of Culture, Republic of Korea, "Korea's Policy Responses to Covid-19: Building Resilience for Culture, Sports and Tourism," [https://www.k-culture.jp/link_files/Responses%20to%20covid-19%20ROK\(final\).pdf](https://www.k-culture.jp/link_files/Responses%20to%20covid-19%20ROK(final).pdf).

		Нэгдсэн дотоодын, бүсийн, олон улсын хүчирхэг маркетингийг хэрэгжүүлэх, Гадаадын жуулчдыг Кенид авчрахын тулд виз олголтыг хялбаршуулах, зочид буудлуудын үнийг эргэж харах, танилцуулах аялал зохион байгуулах. ²⁴
4	Австрали	<ul style="list-style-type: none"> - Шалгуур хангасан аж ахуйн нэгжүүдэд ажлын байр хадгалсны мөнгө, ажилтан бүрд 2 долоо хоногт 1,500 австрали доллар тооцож 2020 оны 9 сар хүртэл олгосон. - Жижиг дунд аж ахуйн нэгжүүдэд урсгал зардалд нь нэмэрлэх зорилгоор 100,000 австрали доллар хүртэл олгосон. - Хүндрэлтэй байгаа аж ахуйн нэгжүүдэд татвар төлөлтийг хойшлуулах - Сургалт мэргэшлийг тасалдуулахгүйн тулд дадлагажигч ажилтны цалингийн 50 хувийг 1-9 сард олгосон. Үүнийг 2021 оны 3-р сар хүртэл сунгасан. - 2020 оны 10 сараас – 2022 оны 6 сар хүртэл худалдаж авсан томоохон хөрөнгийн бүтэн үнийн дүнг элэгдэл болгож тооцож болно. Өмнөх худалдан авалтын 150,000 австрали доллар хүртэлх үнийн дүнг элэгдэл болгон тооцох. - ЖДҮ-ийн зээлийн 50 хувийг Засгийн газраас батлан дааж, зээлийн хүүг бага байлгах арга хэмжээ авсан. - Аялал жуулчлалын томоохон үзмэрүүд, тусгай хамгаалалттай газруудын төлбөрийг чөлөөлж, урлаг соёлыг дэмжин, арга хэмжээ зохион байгуулах зэрэгт 1 тэрбум австрали доллар төсөвлөжээ. - Агаарын тээврийн компаниуд, нисэх буудлуудад дэмжлэг болгон улсын хураамжаас чөлөөлсөн²⁵.

3.3 Олон улсын эдийн засгийн байдал 2020-2023

Олон Улсын Валютын Сангийн тооцооллоор дэлхийн эдийн засаг 2020 онд 3.5 хувиар буурсан байна. Вакцинжуулалт найдлага төрүүлж байгаа ч шинэ давалгаа болон шинэ төрлийн вирус илэрч байгаатай холбоотой тодорхойгүй байдал ноёрхож, 2021 онд дэлхийн эдийн засаг 5.5 хувь, 2022 онд 4.2 хувь өснө гэсэн таамаг дэвшүүлж байна²⁶.

2020 онд дэлхий даяар олон улсын зорчигч 1 тэрбумаар буурсан бөгөөд аялал жуулчлалын түүхэнд байсан хамгийн муу он боллоо гэж Дэлхийн Аялал Жуулчлалын Байгууллага тэмдэглэжээ²⁷. Үүний улмаас дэлхийн нийт экспорт 1.3 их наяд ам долларын алдагдал хүлээсэн бол, 100-120 сая ажлын байр үгүй хийх эрсдэлд оруулсан гэж тооцоолсон байна. Дэлхийн Аялал Жуулчлалын Зөвлөлийн мэдээллээр дэлхийд аялал жуулчлалын салбар нийт 320 сая хүнийг ажлын байраар хангадаг бөгөөд Ковид-19 цар тахал нь 50 сая ажлын байрыг үгүй хийх эрсдэлд оруулсан гэж тооцоолжээ²⁸. Тус судалгаагаар 2023-2024 оноос нааш аялал жуулчлал хуучин хэвэндээ орохгүй гэж мэргэжилтнүүд хариулсан байна. 2020 онд Ази номхон далайн орнуудын авсан гадаадын жуулчдын тоо 84 хувь,

²⁴ Ministry of Tourism and Wildlife Government of Kenya, "Covid-19 and Travel and Tourism in Kenya Policy Brief," <https://www.tourism.go.ke/wp-content/uploads/2020/10/COVID-19-AND-TRAVEL-AND-TOURISM-IN-KENYA-POLICY-BRIEF.pdf>.

²⁵ The Treasury Australian Government, "Economic Response to the Coronavirus," <https://treasury.gov.au/coronavirus>.

²⁶ IMF, "World Economic Outlook Update," <https://www.imf.org/en/Publications/WEO/Issues/2021/01/26/2021-world-economic-outlook-update>.

²⁷ UNWTO, "2020: Worst Year in Tourism History with 1 Billion Fewer International Arrivals" <https://www.unwto.org/news/2020-worst-year-in-tourism-history-with-1-billion-fewer-international-arrivals>.

²⁸ WTTC, "Latest Research from Wttc Shows a 50% Increase in Jobs at Risk in Travel & Tourism," <https://wttc.org/News-Article/Latest-research-from-WTTC-shows-a-50-percentage-increase-in-jobs-at-risk-in-Travel-and-Tourism>.

Ойрхи дорнод болон Африк 75 хувь, Европ 70 хувь, Америк тив 69 хувь-иар тус тус буурчээ.

Дэлхийн Аялал Жуулчлалын Байгууллагын судалгаагаар 2021 оныг таамаглахдаа 45 хувь нь 2020 оноос илүү байна, 25 хувь нь ижилхэн түвшинд байна, харин 30 хувь нь байдал дордоно гэж үзжээ. 2020 оны 10-р сард судалгаа авахад оролцогчдын 21 хувь нь 2022 оноос нааш салбар сэргэхгүй гэж үзэж байсан бол онд 2021 оны судалгаагаар 50 хувь болж нэмэгджээ. Мэргэжилтнүүдийн таамаглалаар аялал жуулчлал сэргэх үед байгалийн, удаан хугацаа зарцуулдаг аяллууд илүү их эрэлт хэрэгцээтэй гэж үзсэн²⁹ нь Монгол улсын хувьд боломж гэж харж болох юм.

4.МОНГОЛ УЛСЫН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЛБАРЫН НӨХЦӨЛ БАЙДАЛ

4.1 Цар тахал “Ковид-19” Монголд

Цар тахлын үед Монгол улсын Гамшгаас хамгаалах тухай хуулийн хүрээнд бэлэн байдлын гурван шатлал бүхий зэрэглэлийг мөрдөн ажиллаж байна. Үүнд:

1. Өдөр тутмын бэлэн байдал буюу ногоон түвшин;
2. Өндөржүүлсэн бэлэн байдал буюу шар, улбар шар түвшин;
3. Бүх нийтийн бэлэн байдал буюу улаан түвшин гэх гурван ангилал багтаж байна.

Бэлэн байдлын зэрэгт шилжсэн үед төрийн байгуулага, хуулийн этгээд, иргэдийн хориглох болон зөвшөөрөх үйл ажиллагааны жагсаалтыг Зураг 4-т үзүүлээ.

Монгол улсад ковид-19 вирусын халдвар тархахаас урьдчилан сэргийлж 2020 оны 3-р сараас хилээ хааж, орон даяар өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэн ч 2020 оны 11 сараас дотоод халдвар тархаж хэд хэдэн удаагийн хөл хорио тогтоосон юм.

Цар тахлын үед Улсын Онцгой Комисс (УОК) цар тахлын нөхцөл байдлын эрсдлийн үнэлгээг хийж, цар тахалтай тэмцэх ерөнхий үйл ажиллагааг хариуцаж байгаа бол Халдварт Өвчин Судлалын Үндэсний Төв (ХӨСҮТ) тэргүүтэй эмнэлэгийн салбарынхан өвчний шинжилгээ, оношлогоо, эмчилгээг хариуцан ажиллаж байна. Хууль сахиулах цагдаа, цэргийн байгууллагууд хорио цээрийн үеийн дэглэмийг сахиулах чиглэлд ажиллаж байна.

Харин гамшгаас хамгаалах бэлэн байдлын зэрэгт зэрэгцсэнтэй зэрэгцэн аялал жуулчлалын салбарын дэд салбарууд болон уялдаа бүхий салбарын ихэнх үйл ажиллагааг хориглосон байна. Тухайлбал **өндөржүүлсэн бэлэн байдлын шар түвшинд** хуулийн этгээдийн аялал зугаалга, уралдаан тэмцээн, үзэсгэлэн худалдаа, диско эрхлэх үйл ажиллагаа хориглосон. Харин иргэд гэр бүлээрээ аялал зугаалгад хамрагдаж болж байна. **Өндөржүүлсэн бэлэн байдлын улбар шар** түвшинд шар түвшний хязгаарлалт улам өргөжиж соёл урлаг, үзвэр үйлчилгээг, саун бассейний үйлчилгээг 30 хувийн дүүргэлттэй хязгаарлаж, дэн буудал, сүм хийд, мөргөлийн газрууд, биеий тамир спортын арга хэмжээг бүрэн хоригложээ. Аялал зугаалга, хурим найр, цайллаг хүлээн авалт, баар диског

²⁹ UNWTO.

мөн хориглосон. Ийнхүү аялал жуулчлалын салбарын үйл ажиллагаа цар тахлын үед бүрэн хориглогджээ.


Зураг 4. Монгол улсын бэлэн байдлын гурван шатлал бүхий зэрэглэл

КОРОНАВИРУСТ ХАЛДВАР (КОВИД-19)-ЫН ТАРХАЛТЫН ТҮВШИН ТОГТООХ, ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЗОХИЦУУЛАХ ТҮР ЖУРАМ				
зэрэглэл	түвшин	ТӨРИЙН БАЙГУУЛЛАГА	ХУУЛИЙН ЭТГЭЭД	ИРГЭН
өдөр тутмын бэлэн байдал	I	Халдвараас сэргийлэх дэглэм сахиулах	Байгууллага, аж ахуйн нэгж, иргэд мэргэжлийн байгууллагаас гаргасан заавар зөвлөмж, халдвар хамгааллын дэглэм сахиулах	Иргэд мэргэжлийн байгууллагаас гаргасан заавар зөвлөмж, халдвар хамгааллын дэглэм сахиулах
өндөржүүлсэн бэлэн байдал	II	Хязгаарлах үйл ажиллагаа: 1. Уралдаан, тэмцээн, аялал зугаалга.	Хязгаарлах үйл ажиллагаа: 1. Уралдаан, тэмцээн; 2. Аялал зугаалга /гэр бүлээс бусад/; 3. Өргөтгөсөн болон үзэсгэлэн худалдаа; 4. Диско байр; 5. Цахим тоглоомын газар, хүүхдийн тоглоомын төв. Зруул мэндийн байгууллын хийсэн эрдэгийн үнэтэнд үндэслэн УОК энэ түвшинд өөрчлөлт оруулж болно.	Хязгаарлах үйл ажиллагаа: 1. Уралдаан, тэмцээн; 2. Аялал зугаалга /гэр бүлээс бусад/; 3. Өргөтгөсөн болон үзэсгэлэн худалдаа; 4. Цахим тоглоомын газар, хүүхдийн тоглоомын төв. Зруул мэндийн байгууллын хийсэн эрдэгийн үнэтэнд үндэслэн УОК энэ түвшинд өөрчлөлт оруулж болно.
	III	Хязгаарлах үйл ажиллагаа: 1. Бүх төрлийн байр ёслол, тэмдэглэлт ойн арга хэмжээ, жуулал, цуглаан, цайллага, хүлээн авалт; 2. Олимп, олон улсын тэмцээний бэлтгэлээс бусад биеийн тамир, спортын үйл ажиллагаа (дотоод орчид 10 хүртэл хүнтэй байх); 3. Соёл, урлагийн байгууллагын үйл ажиллагаа.	Хязгаарлах үйл ажиллагаа: 1. Жагсаал, цуглаан, уралдаан, тэмцээн; 2. Аялал зугаалга, хурим найр, цайллага, хүлээн авалт; 3. Баар /Диско, караоке/; 4. Өргөтгөсөн болон үзэсгэлэн худалдаа; 5. Цахим болон бүх төрлийн тоглоомын газар; 6. Сургалтын төв /танхимын болон үйлдвэрлэлийн сургалт 10 хүртэл хүнтэй байх/; 7. Соёл урлаг; 8. Үзвэр үйлчилгээ /нийт суудлын тооны 30 хувиас ихгүй байх/; 9. Алхаал тайлах төв; 10. Чийрэгжүүлэх, бялдаржуулах төв /нийт хүчин чадлын 30 хувиас ихгүй байх/; 11. Саун, бассейн /нийт хүчин чадлын 30 хувиас ихгүй байх/; 12. Дэн буудал; 13. Шашны зан үйл, сүм хийд, мөргөлийн газрууд; 14. Олимп, олон улсын тэмцээний бэлтгэлээс бусад биеийн тамир, спортын арга хэмжээ /дотоод орчид 10 хүртэл хүнтэй байх/.	Хязгаарлах үйл ажиллагаа: 1. Жагсаал, цуглаан, уралдаан, тэмцээн; 2. Аялал зугаалга, хурим найр, цайллага, хүлээн авалт; 3. Өргөтгөсөн болон үзэсгэлэн худалдаа; 4. Цахим болон бүх төрлийн тоглоомын газар; 5. Сургалтын төв /танхимын болон үйлдвэрлэлийн сургалт 10 хүртэл хүнтэй байх/; 6. Соёл урлаг; 7. Үзвэр үйлчилгээ /нийт суудлын тооны 30 хувиас ихгүй байх/; 8. Алхаал тайлах төв; 9. Чийрэгжүүлэх, бялдаржуулах төв /нийт хүчин чадлын 30 хувиас ихгүй байх/; 10. Саун, бассейн /нийт хүчин чадлын 30 хувиас ихгүй байх/; 11. Дэн буудал; 12. Шашны зан үйл, сүм хийд, мөргөлийн газрууд; 13. Шашны зан үйл, сүм хийд, мөргөлийн газрууд; 14. Олимп, олон улсын тэмцээний бэлтгэлээс бусад биеийн тамир, спортын арга хэмжээ /дотоод орчид 10 хүртэл хүнтэй байх/.
бүх нийтийн бэлэн байдал	IV	Хязгаарлахгүй үйл ажиллагаа: 1. Төрийн байгууллага /эвхлэн, албан хаагчийн 5-10 хүртэл хувь ажиллах, цагийн хязгаар тогтоох/; 2. Зрүүл мэндийн байгууллага; 3. Тусгайлан чиг үүрэг бүхий байгууллагууд /байгаль орныг хамгаалах, гааль, дипломат алба, онцгой байдал, мэргэжлийн хөнгөлт, Зөвсөлт хүчин бусад цэрэг, татвар, тусгай алба, гадардын иргэн, харьяат, улсын бүртгэл, цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх/; 4. Шүүх, прокурор, өмгөөлөгч, нотариат; 5. Улсын онц чухал болон стратегийн ач холбогдол бүхий объект, байгууллага /тусгай цагийн хуваарьтай ажиллах, Засгийн газрын 2017 оны 281 дүгээр тогтоомыг баримтлах/; 6. Эрчим хүч, дулаан, усан хангамж, ариутгал, нийтийн аж ахуй; 7. Шүүдэн, харилцаа холбоо; 8. Шатаахуйн, түлшний үйлдвэрлэл, хангамж, нийлүүлэлт, түгээлт, тусгай зөвшөөрөл бүхий байгууллагын түлшний тээвэрлэлт, худалдаа; 9. Геологи, хайгуул, уул уурхай, газрын тооны олборлолт; 10. Зайны сургалт, хүүхэд хамгааллын үйлчилгээ, асрамж, халамж, түр хамгаалах байр, Монголын улаан загалмай нийгэмлэг; 11. Цахим банк, автомат тооцооны машинаас; 12. Газар тариалан, мал, амьтны өвс, тээвэрлэлийн түгээлт, тээвэрлэлт.	Хязгаарлахгүй үйл ажиллагаа: 1. Эрчим хүч, дулаан, усан хангамж; 2. Зрүүл мэндийн байгууллага, эмийн сан, эм, эмнэлгийн хэрэгсэл ханган нийлүүлэх байгууллага; 3. Өмгөөлөгч, нотариат; 4. Шатаахуйн, түлшний хангамж; 5. Хүнс, ахуйн хэрэгсэлний үйлдвэрлэл, худалдаа, тээвэрлэлт, түгээлт, ханган нийлүүлэлт, сав баглаа боодол; 6. Ариутгал, халдваргүйжүүлэлт, жог хаягдлын цэвэрлэгээ, ажилт, цуглуулалт, тээвэрлэлт; 7. Цахим банк, автомат тооцооны машинаас; 8. Газар тариалан, өвс тээвэрлэлт, түлшний үйлдвэрлэл, нийлүүлэлт, түгээлт, тээвэрлэлт, худалдаа; 9. Харилцаа холбоо, шуудан итгэмж; 10. Улсын онц чухал болон стратегийн ач холбогдол бүхий объект, тусгайлан чиг үүрэг бүхий байгууллагын үйл ажиллагааг тасралтгүй хангах аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаа /арх бүхий байгууллагын зөвшөөрснөөр/; 11. Хэвлэл мэдээлэл /арх хязгаарлах/; 12. Эрх бүхий байгууллагын зөвшөөрөлтэй харуул хамгаалалтын байгууллага; 13. Геологи, хайгуул, уул уурхай, газрын тооны олборлолт; 14. Орон сууц, нийтийн үйлчилгээний контор, сууц өмчлөгчдийн холбоо; 15. Буяны үйл ажиллагаа.	Хязгаарлахгүй үйл ажиллагаа: 1. Эмнэлгийн зайлшгүй тусламж, эмийн сан; 2. Өмгөөлөгч, нотариат; 3. Тулш худалдан авах; 4. Хүнс, ахуйн хэрэгсэлний бараа бүтээгдэхүүн худалдан авах; 5. Газар тариалан; 6. Зөөврийн ус; 7. Шянгилгээ өгөх; 8. Буяны үйл ажиллагаа.

Эх сурвалж: УОК, <http://erennews.mn>

Ковид-19-ийн халдвар дотоодод тархснаас улбаалсан **бүх нийтийн бэлэн байдлын зэрэг буюу улаан зэрэгт** 2021.11.12-с эхлэн 20 хоног, 2021.12.23-с эхлэн 20 хоног, 2021.12.14-с эхлэн 10 хоногийн хугацаатай тогтоогоод байна. Орон даяар бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэн ч Ковид-19-ийн халдвар Дархан-Уул, Сэлэнгэ аймаг, Улаанбаатар хотуудад халдвар голомтлон гарч халдварын эрсдэл болон тоо хэмжээ улам нэмэгдсээр байна. Уг судалгааг гүйцэтгэснээс хойш цар тахлын нөхцөл байдал өөрчлөгдөж Говь-Алтай аймгаас бусад бүх аймагт Ковид-19-ийн халдвар тархаад байна.

Зураг 5. Монгол улсад бүртгэгдсэн Ковид-19-ийн тархварзүйн муруй




Эх сурвалж: <https://ikon.mn/n/23cv>

4.2 Цар тахлын эсрэг Монгол улсын хэрэгжүүлж буй бодлого, арга хэмжээний аялал жуулчлалын салбарт үзүүлэх нөлөөллийн шинжилгээ

Монгол улс ковид цар тахлаас сэргийлэх хариу арга хэмжээ авсны тэргүүнд олон улсын жуулчдыг нэвтрүүлэхийг хориглож хилээ хаасан юм. Монгол улсын жуулчдын тоо сүүлийн 10 жилд харьцангуй жигд өсөлттэй байж 2019 онд 577.3 мянгад хүрч байсан бол Ковид-19-ийн үед буюу 2020 онд энэ тоо даруй 89.8 хувиар буурч 58.9 мянга болсон байна. Үүний 62 хувь нь 2020 оны эхний улиралд зочилсон байв (Зураг 6).

Зураг 6. Монгол улсад 2000-2020 онд аялсан гадаадын жуулчдын тоо, өсөлтийн хувиар



Эх сурвалж: www.1212.mn

2020-2022 онд Ковид-19 гараагүй гэж төсөөлж, 2014 оноос хойших өгөгдөлд үндэслэн регрессийн шинжилгээ хийхэд Жуулчдын тоо = $40483.5 * t +$

318172.6 (*Adjusted R*² = 0.87, *t* – Stat = 6.1, *p* – value = 0.003) тэгшитгэлээр илэрхийлэгдэж байна. Энэ регрессийн тэгшитгэлийг ашиглан 2020-2022* оны жуулчдын тоог тооцож Хүснэгт 3-т харуулав.

Хүснэгт 3. Жуулчдын тоо*

t	Он	Жуулчдын тоо	Монгол Банк, Аялал жуулчлалын хөгжлийн төвөөс (2019) хийгдсэн Аялал жуулчлалын салбарын өнөөгийн байдал, шийдвэрлэх асуудлууд түүвэр судалгаанд нэг жуулчны дунджаар зарцуулах зардал 2,048 ам.доллар гэж тооцсон байна. Энэ зардлын үнэлгээг ашиглан гадаадын жуулчдаас олсон орлогын албан статистик тооцоонд тулгуурлан (ҮСХ, 2020) тооцоолж үзэхэд дунджаар нийт орж ирсэн жуулчдын 34.53 хувь нь дээрх орлогыг бүрдүүлж байна (Хүснэгт 4).
1	2014	392,844.	
2	2015	386,204.	
3	2016	404,163.	
4	2017	469,309.	
5	2018	529,370.	
6	2019	577,300.	
7*	2020	601,557	
8*	2021	642,041	
9*	2022	682,524	

Хүснэгт 4. Ковид-19-ийн нөлөөллөөс эдийн засагт учирч болзошгүй хохирол (2020-2022 он)

Он	Жуулчдын тоо	Гадаадын жуулчдаас олсон орлого, сая ам.доллар	Гадаадын жуулчдаас олсон орлого, тэрбум төгрөг	Ханш, 1 ам.доллар	2048\$ зарцуулж буй жуулчдын тоо, мян.хүн	2048\$ зарцуулж буй жуулчдын эзлэх хувь
2015	386,204.	231.14	455.5	1970.66	112.86	29.22%
2016	404,163.	278.25	597.6	2147.74	135.86	33.62%
2017	469,309.	345.85	844.1	2440.63	168.87	35.98%
2018	529,370.	387.72	958.7	2472.67	189.32	35.76%
2019	577,300.	449.97	1,198.7	2663.94	219.71	38.06%
2020	601,557	425.39	1,212.32	2,849.89	207.71	34.53%
2021	642,041	454.02	1,372.01	3021.93	221.69	34.53%
2022	682,524	482.65	1,540.94	3192.70	235.67	34.53%
Нийт буй алдагдал	хүлээгдэж	1,362.06	4,125.27			


Эх сурвалж: Судлаачийн тооцоо

Ковид-19-өөс үүдэлтэй аялал жуулчлалын салбарын орлого 2020 онд гэхэд 1.2 их наяд төгрөгийн алдагдал хүлээгээд байгаа ба энэ байдал 2021-2022 онд үргэлжилнэ гэж тооцвол нийтдээ 4.13 их наяд төгрөгийн орлогыг алдах магадлалтай байна. Иймд, Засгийн газар бодлогоор аялал жуулчлалын салбарыг дэмжих ирээдүйд хүлээгдэж буй алдагдлыг бууруулах, үүний эсрэг сөрөг арга хэмжээ авах зайлшгүй шаардлага үүсээд байна. Эс бөгөөс тус салбарт ажиллаж 88,700 гаруй хүний ажлын байр эрсдэлт байдалд орж байна (ҮСХ, 2020).

4.3 Цар тахал ба дотоодын аялал жуулчлалын төлөв байдал

Цар тахлаас улбаалан тур оператор байгууллагууд олон улсын жуулчдад үйлчлэх боломжгүй болж дотоодын аялал жуулчлалд найдлага тавьж байлаа. Гэсэн хэдий ч “дотоодын аялагчдын 96 хувь нь аяллаа хувиараа зохион байгуулна гэсэн бол аялал жуулчлалын компаниар болон аяллын клубээр дамжин аялах бүлэг дөнгөж 5 хувь эзэлж байна” (Амартүвшин ба бусад, 2020) (Зураг 7). Эндээс дүгнэхэд дотоодын аялагчид тур оператор байгууллагаар үйлчлүүлэх нь түгээмэл бус байсаар байгаа нь харагдаж байна.

Зураг 7. Дотоодын аялагчдын дотоодод аяллын төлөв байдал (2020 он)



Эх сурвалж: (Амартүвшин ба бусад, 2020)


5. СУДАЛГААНЫ ҮР ДҮН: ЦАР ТАХЛЫН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЛБАРТ УЧРУУЛЖ БҮЙ ЭДИЙН ЗАСГИЙН НӨЛӨӨЛӨЛ

5.1 Инбаунд, аутбаунд, дотоодын зах зээлийн тойм

Монгол улсад 2020 оны байдлаар тур операторын гэрчилгээ бүхий 570 байгууллага үйл ажиллагаа явуулж байна (МАЖХ, 2020). Үүнээс 80 байгууллага 2020 онд шинээр бүртгэгдэж, гэрчилгээжжээ. Судалгааны зарим асуултууд 2019 оны нөхцөл байдлыг илрүүлэх зорилготой байсан тул 2020 онд шинээр бүртгүүлсэн тур операторуудыг хамаарахгүй асуултуудад тооцоогүй ба 2019 онд 490 тур оператор үйл ажиллагаа явуулж байсны 392 нь инбаунд зах зээл дээр ажиллажээ (МАЖХ, 2020).

Уг судалгаанд нийт 252 тур оператор хамрагдсан нь тур операторын гэрчилгээ бүхий байгууллагын 44.2 хувийг эзэлж байна. Судалгаанд хамрагдсан тур операторын 202 (80%) нь инбаунд тур оператор байлаа. Харин аутбаунд зах зээлд ажилладаг 67 (26.5%), дотоодын аяллын зах зээлд ажилладаг 70 (27.7%) тур операторууд судалгаанд хамрагдсан байна. Нийт 252 тур операторын 47 хувь нь 2011-2020 онд байгуулагдсан бол 39 хувь нь 2000-2010 онд байгуулагджээ. Харин 1999 оноос өмнө байгуулагдсан компаниуд 12.6 хувийг бүрдүүлж байна (Зураг 8).


Зураг 8. Тур операторуудын байгуулагдсан он




5.2 Голлох зах зээл

Түүвэр судалгаанд хамрагдсан инбаунд байгууллагуудын голлох зах зээлийн эхний тавд АНУ (47%), Франц (30%), Герман (30%), Их Британи (26%), Өмнөд Солонгос (24%) улсууд багтсанаас Өмнөд Солонгосоос бусад нь холын зайн нислэгээр холбогддог улсууд байна. Харин удаах тавд Австрали (22%), Япон (20%), Швейцар (19%), Итали (18%), БНХАУ (16%) оржээ. Эдгээрээс Япон, Хятадаас бусад нь мөн л холын зайн нислэгээр холбогдож байна. Монгол улс эдгээр арван улсын дөрөвтэй (Өмнөд Солонгос, Хятад, Япон, Герман) нь шууд хуваарьт нислэгтэй юм (Зураг 9).

Зураг 9. Голлох зах зээл (улсаар)(n=196)




Зураг 10. Инбаунд аялал жуулчлалын зах зээл (тухайн улсын гол харилцдаг хэлээр) (n=196)



Инбаунд зах зээлийг хэлний бүлгээр авч үзвэл Англи хэлтэй зах зээл Герман, Франц, Солонгос, Хятад, Япон хэлтэй зах зээлээс ойролцоогоор 3-7 дахин том хэмжээтэй байна. Өөрөөр хэлбэл Монголын тур операторуудын хувьд голлох Европ, Хойд Америкийн Англи, Герман, Франц хэлтэй зах зээл Азийн голлох зах зээл (Солонгос, Хятад, Япон)-ээс 3 дахин том байна (Зураг 10). Монгол улсын аялал жуулчлалын сурталчилгаанд эдгээр хэлээр мэдээлэл хүргэх нь илүү ач холбогдолтой байх боломжтой юм.

Инбаунд тур операторуудын хүлээн авч үйлчилсэн жуулчны тоог харьцуулбал нийт 117 байгууллагын 51 хувь нь 200 хүртэлх тооны жуулчин хүлээн авч байхад 22.2 хувь нь 201-400 жуулчин хүлээн авчээ. Удаах 17 хувь нь 401-1,000 жуулчинд үйлчилсэн байна. Нийт тур операторын 9.2 хувь нь хамгийн олон буюу 1,001-9,000 жуулчинд үйлчилсэн байна. Энэ мэдээлэлд үндэслэн инбаунд тур оператораар үйлчлүүлсэн нийт жуулчдын тоо дунджаар 65,200, хамгийн ихдээ 80,300 байна. МАЖХ-с гэрчилгээжсэн 392 байгууллагын нийлбэр дүнгээр тоймловол нийт инбаунд тур оператороор үйлчлүүлсэн жуулчдын тоо 215,160-264,990 орчим байх боломжтой байна. Энэ Монголд 2019 онд жуулчилсан гадаадын жуулчдын 42-52 хувь юм (Зураг 11).

Зураг 11. Инбаунд тур операторын хүлээн авсан жуулчны тоо




6. ҮНДЭСНИЙ ЭДИЙН ЗАСАГТ ОРУУЛЖ БУЙ ТУР ОПЕРАТОР ЭДИЙН ЗАСГИЙН НӨЛӨӨ

6.1 Борлуулалтын орлого ба дам үр ашиг


Нийт 252 тур оператор байгууллагын 141 (56%) нь жилийн борлуулалтын орлогын талаар хариулсан бөгөөд тэдний нийт борлуулалтын орлого 2019 онд 131.7 тэрбум төгрөг (49.7 сая ам доллар) байснаас тур оператор байгууллагуудтай уялдаатай ажилладаг бусад салбар, бүрдэл хэсгүүдэд дахин хуваарилагдаж эхний шатанд дам үр ашгийг буй болгож байна.

Үүнээс 50 сая төгрөг хүртэлх орлоготой байгууллага 27.6 хувь, 51-500 сая төгрөгийн орлоготой байгууллага 39 хувь байна. Харин 501 саяас их төгрөгийн орлоготой компани ойролцоогоор 1/3 нь байна. Мөн 19.1 хувь нь 501 сая-1 тэрбум төгрөгийн орлоготой байна. Харин 1.1-5 тэрбумын борлуулалтын орлоготой байгууллага 9.9 хувь байгаа бол 5.1-10 тэрбум болон 10.1 тэрбумаас их орлоготой байгууллага 2.8 хувь болон 1.4 хувь тус тус эзэлж байна (Зураг 12).

Зураг 12. Нийт тур операторын борлуулалтын орлого (2019 он) (n=141)



Зураг 13. Инбаунд тур операторын борлуулалтын орлого (2019 он) (n=120)



Тур операторуудын 2019 оны борлуулалтын орлого аялал жуулчлын бусад дэд салбарт хэрхэн хуваарилагдаж байгааг тооцож гаргав (Хүснэгт 5). Тур операторын үндэсний эдийн засагт оруулж буй орлогын байдлаас дүгнэхэд гэр бааз (13.1 тэрбум), дотоодын тээвэр (12.2 тэрбум), зочид буудал (11.1 тэрбум), хоол ундаа (10.1 тэрбум) зэрэгт хамгийн ихийг зарцуулжээ. Доорх хүснэгтээс ажиглахад зөвхөн сурталчилгаанд 6.8 тэрбум төгрөг буюу 2.57 сая ам доллар зарцуулжээ. Өөрөөр хэлбэл нийт орлогынхоо 5.2 хувийг сурталчилгаанд зарцуулж байж 577,300 жуулчны 50 хувийг Монгол улсад татжээ. Гэсэн хэдий ч энэ нь бодит байдлаас хамаагүй бага дүн бөгөөд 141 байгууллагын мэдээлэлд үндэслэлээ. Бодит дүн ойролцоогоор 2-2.7 дахин өндөр байхаар байна.

Хүснэгт 5. Тур операторуудын үндэсний эдийн засаг оруулж буй орлого (хамаарал бүхий салбараар), жин

Тур операторын 2019 оны борлуулалтын орлогын бусад дэд салбартаа хуваарилалт	Тур операторуудын 2019 оны нийт борлуулалтын орлогын салбарт хуваарилагдсан байдал, сая.төг	Дэд салбарт хуваарилагдах хэмжээ, хувь %
Ажиллагсдын цалин	27,614.2	21.0%
Дотоодын тээвэр (агаар, авто, төмөр, усан замын тээвэр)	12,294.9	9.3%
Хоол, Ундаа	10,169.1	7.7%
Соёл, спорт, хурал зөвөлгөөний арга хэмжээ	2,522.6	1.9%
Даатгал	1,797.7	1.4%
Малчин айл (хоноглох, морь түрээслэх г.м)	5,372.9	4.1%
Аяллын тоног хэрэгсэл	4,534.4	3.4%
Зочид буудал	11,125.9	8.4%
Гэр бааз	13,198.5	10.0%
Гадаад аяллын багц (зөвхөн аутбаунд аяллын компанид хамаарна)	3,554.2	2.7%
Урсгал зардал (оффис түрээс, утас, интернет г.м.)	6,983.1	5.3%
Маркетинг (гадаад, д сурталчилгаа, нислэг, томилолт, цахим, ц- бус сурталчилгаа г.м.)	6,831.2	5.2%
Сургалт	1,718.7	1.3%
Цэвэр ашиг	17,842.9	13.5%
Бусад	6,155.9	4.7%
Нийт борлуулалт, 2019 он сая.төг	131,716.2	100.0%

6.2 Ажил эрхлэлт

Ажил эрхлэлтийн талаарх асуултад нийт 215 тур оператор хариулсан ба эдгээрт 10,195 хүн ажиллаж байгаагаас байнгын ажилтай 3,443 (32,8%), улирлын ажилтай 6,752 (67.2%) хүн байна. Байнгын ажиллагсдын дунд оффисийн ажилтан хамгийн олон буюу 1,058 байгаа бол 898 жолооч, 817 хөтөч, 226 тогооч бусад чиглэлийн 354 ажилтан байна (Хүснэгт 6).

Хүснэгт 6. Тур операторын байнгын ажилчдын тоо /2019 он/

Ажиллагсад	Нийт	Хариулсан
Оффист	1,058	215
Жолооч	898	149
Хөтөч	817	137
Бусад	354	75
Тогооч	226	91
Нийт	3,353	

Аялал жуулчлалын салбарын онцлогтой уялдан жуулчны улиралд гэрээт ажилтан ажиллуулах нь түгээмэл бөгөөд нийт 6,752 гэрээт ажиллагсад

байгаагийн 42 хувь нь хөтөч, 40 хувь нь жолооч байна. Харин оффисийн ажилтан, тогооч, бусад ажиллагсад тус бүр 5-7 хувийг эзэлж байна (Хүснэгт 7).


Хүснэгт 7. Тур операторын гэрээт ажилчдын тоо /2019 он/

Ажиллагсад	Нийт гэрээт	Хариулсан
Оффист	2,829	189
Жолооч	2,677	181
Хөтөч	439	72
Бусад	306	125
Тогооч	226	115
Нийт	6,752	

6.3 Цар тахлын үеийн хүндрэл, бэрхшээл

Тур операторуудын орлого 2020 онд өмнөх онтой харьцуулахад 91-100 хувь буурсан 104 компани байгаа бөгөөд уг асуултад хариулсан 118 байгууллагын 88 хувийг эзэлж байна. Харин цөөн тооны буюу 11 байгууллагын орлого 61-90 хувь буурсан байна (Зураг 14).


Зураг 14. Борлуулалтын орлогын өөрчлөлт (n=118)




Тур операторуудын санхүүгийн хүндрэл ажиллах хүчинд хэрхэн нөлөөлж байгааг доорх зураглалаас харж болохоор байна. Ажиллагсдын цомтхотголын талаар 135 байгууллага мэдээллэхдээ 2020 онд тэдний 54.8 хувь нь ажиллагсдаа их, бага хэмжээгээр цөөрүүлжээ. Гэсэн хэдий ч давхардсан тоогоор 54 хувь нь ажиллагсдаа бизнесийн өөр салбарт шилжүүлэх болон хуучин хэвээр хадгалсаар байна (Зураг 15).

Нийт 85 тур операторын 62 гаруй хувь нь 1-5 ажиллагсдаа цотхотгожээ. Нийт цомхотгосон ажиллагсад эдгээр байгууллагын хувьд хамгийн багаар тооцоход 392, хамгийн ихдээ 692 орчим байна (Зураг 16).

Зураг 15. Ажиллагсдаа цомхотгосон эсэх




Зураг 16. Ажиллагсдаа цомхотгосон байдал




Сүүлийн 3 сарын ашиглалтын зардлаа төлсөн эсэхийг асуухад 138 байгууллага хариулж, 65 буюу 47.1хувь нь төлөөгүй гэж хариулсан нь нөхцөл байдал хүнд байгааг харуулж байна. Асуулгад оролцогсдын 60 нь буюу 43.48 хувь нь зээлтэй бөгөөд зээлтэй байгууллагуудын 42 буюу 71.19 хувь нь сүүлийн 6 сард зээлээ төлж чадаагүй гэж хариулжээ.

Нийт 134 тур операторын 98 нь буюу 73.1 хувь нь 2020 онд ажиллагсдынхаа цалинд өөрчлөлт оруулжээ. Цалингийн өөрчлөлтийн талаар 100 компани хариулжээ. Эдгээрээс цалингаа 91-100 хувь бууруулсан нь хамгийн олон буюу 37 хувь байна. Ажиллагсдаа цалинжуулаагүй ч 20 хувь нь НДШ-ийг нь төлж байна. Цалингаа 31- 50 хувь хүртэл бууруулсан нь 19 хувийг эзэлж байна. Цалингаа хамгийн бага хувиар бууруулсан (1-30%) нь нийт тур операторын дөнгөж 10 хувь байна. Маш цөөн 2 хувь нь цалиндаа өөрчлөлт оруулаагүй байна (Зураг 17-18).

Зураг 17. Ажиллагсдын цалингийн өөрчлөлт (n=134)




Зураг 18. Цалингийн өөрчлөлт (n=100)



Нийт 137 тур операторын 50 хувь нь ажиллагсдаа цаашид цалинжуулах боломжгүй бол 34 хувь нь 2-6 сар, 15 хувь нь 7-15 сарын хугацаанд цалинжуулах боломжтой байна. Өөрөөр хэлбэл 2021 оны 6 сар гэхэд нийт тур операторын 84 хувь нь буюу 10 компани тутмын 8 нь ажиллагсдаа цалинжуулах боломжгүй болохоор байна (Зураг 19).

Зураг 19. Ажиллагсдаа цалинжуулах боломж (n=137)



Инбаунд, аутбаунд, дотоодын тур операторуудын хувьд бага зэрэг ялгаатай байна. Инбаунд тур операторын 46.2 хувь нь ажилчдаа цалинжуулах боломжгүй бол 38.6 хувь нь 4-6 сарын дараагаас цалин олгох боломжгүй болж байна. Маш цөөхөн 3.4 хувь нь 1 жилээс урт хугацаанд цалингаа олгох боломжтой гэжээ. Аутбаунд болон, дотоод аяллын тур операторууд ижилхэн нөхцөлтэй буюу 50 хувь нь цалин олгох боломжгүй, 10 хувь нь 7-12 сар цалинжуулах, 40 хувь нь 6 сар хүртэлх хугацаанд ажилчдаа цалинжуулах боломжтой байгаа ч тэдний тоо инбаунд компаниудтай харьцуулахад цөөн байна (Зураг 20).

Зураг 20. Ажиллагсдаа цалинжуулах боломжит хугацаа

	1 сар	2-3 сар	4-6 сар	7-12 сар	12-15 сар	16 сараас дээш	Цалинжуулах боломжгүй	Нийт
Инбаунд	2.5%	19.3%	16.8%	11.8%	1.7%	1.7%	46.2%	100.0%
Аутбаунд	2.6%	13.2%	23.7%	10.5%			50.0%	100.0%
Дотоодын 33	2.6%	13.2%	23.7%	10.5%			50.0%	100.0%

Цар тахлын үеийг давах хөрөнгийн эх үүсвэр Зураг 21-т харуулсанчлан давхардсан тоогоор дараах байдалтай байна. Хуримтлагдсан ашигаар-39 хувь, төрөл бүрийн зээлийн эх үүсвэрээр бүрдүүлж байгаагаас найз нөхдийн зээл- 34 хувь, банкны зээл-20 хувь, гадаад түншийн зээл-17 хувьтай байна. Аяллын урьдчилгаа төлбөрөөр-32 хувь нь цар тахлын үеийн хүндрэлтэй нөхцөл байдлыг

даван туулж байна. Мөн бусад бизнесийн орлогоо ашиглаж буй нь 24 хувийг бүрдүүлж байна. Нийт байгууллагын дөнгөж 17 хувь нь эрсдэлийн сантай байгаа нь бусад байгууллагуудад цаашид хэрэгтэй сайн туршлага болохоор байна.

Зураг 21. Цар тахлын үеийн хөрөнгийн эх үүсвэр (n=133)



Хөрөнгө оруулалт татсан, хувьцаагаа зарсан байгууллагууд тус бүр 2 хувийг эзэлж байна. “Бусад” гэж 24 хувь нь хариулсны дунд “ямар ч арга хэмжээ авах боломжгүй” гэж нэг хүн хариулсан байх ба “өөр салбарт давхар ажилладаг”, “ажилчдын 90 хувийг цомхотгосон” зэргээр хариулжээ.

6.4 Байгууллагын зүгээс цар тахлыг даван туулж буй аргууд

Цар тахлын нөлөөллийг бууруулахын тулд 133 тур операторын 56 хувь нь үйл ажиллагаагаа түр зогсоосон, 39 хувь нь харилцагчдын захиалгыг хойшлуулж, уян хатан нөхцөл санал болгосон, 20 хувь нь дотоодын зах зээлд ажиллах болсон, 18 хувь нь өөр бизнес эхлүүлсэн бөгөөд харамсалтай нь 15 хувь нь үйл ажиллагаагаа бүрмөсөн зогсоосон байна (Зураг 22).

Зураг 22. Цар тахлын нөлөөллийг бууруулахаар тур операторуудын зүгээс авсан арга хэмжээ



Үйл ажиллагаагаа түр болон бүр мөсөн зогсоосон 99 байгууллагад нийтдээ 1,879 хүн ажиллаж байгаа бөгөөд байнгын ажиллагсдын тоогоор 1-70 ажилтантай жижиг, дунд хэмжээтэй байгууллагууд голлож байна (Зураг 23).

Зураг 23. Үйл ажиллагаагаа зогсоосон тур операторуудын ажилчдын тоо

Үйл ажиллагаагаа түр зогсоосон				Үйл ажиллагаагаа бүр мөсөн зогсоосон			
1-5 ажилтантай	32.6%	30	150	1-5 ажилтантай	10.9%	10	50
6-10 ажилтантай	34.6%	18	180	6-10 ажилтантай	9.6%	5	50
11-40 ажилтантай	27.9%	17	680	11-40 ажилтантай	6.6%	4	160
41-70 ажилтантай	44.4%	4	280	41-70 ажилтантай		0	0
71-100 ажилтантай		0	0	71-100 ажилтантай		0	0
101-130 ажилтантай	50.0%	1	130	101-130 ажилтантай		0	0
161-199 ажилтантай		1	199	161-199 ажилтантай		0	0
		71	1,619			19	260

Үйл ажиллагаагаа түр зогсоосон болон бүр мөсөн зогсоосон байгууллагуудын эдийн засаг оруулж буй мөнгөн хувь нэмрийг тооцоолбол нийт 43.82-87.65 тэрбум төгрөг байгаа нь тур оператор байгууллагын 2019 оны борлуулалтын орлогын 67 хувь болж байна. Одоогоор үйл ажиллагаагаа бүр мөсөн зогсоосон байгууллагын алдагдал 4.4-8.9 тэрбум төгрөг байгаа бөгөөд цаашид ямар нэгэн арга хэмжээ авахгүй бол энэ тоо даруй 33.9-78.6 тэрбум төгрөгөөр нэмэгдэхээр байна (Зураг 24).

Зураг 24. Үйл ажиллагаагаа зогсоосон тур операторуудын орлого

Үйл ажиллагаагаа түр зогсоосон тур оператор				Үйл ажиллагаагаа бүр мөсөн зогсоосон тур оператор			
Орлого /Т/	Нийт	Алдагдал дунд	Алдагдал их	Орлого /Т/	Нийт	Алдагдал дунд	Алдагдал их
<50 сая	22 56%	55,000,000	110,000,000	<50 сая	8 21%	20,000,000	40,000,000
51-100 сая	6 43%	300,000,000	600,000,000	51-100 сая	1 7%	50,000,000	100,000,000
101-500 сая	20 50%	8,000,000,000	16,000,000,000	101-500 сая	6 15%	2,400,000,000	4,800,000,000
501-800 сая	8 57%	2,000,000,000	4,000,000,000	501-800 сая	2 14%	500,000,000	1,000,000,000
801 сая-1 тэрбум		-	-	801 сая-1 тэрбум		-	-
1.1-3 тэрбум	5 46%	7,500,000,000	15,000,000,000	1.1-3 тэрбум	1 9.10%	1,500,000,000	3,000,000,000
3.1-5 тэрбум	1 33%	2,500,000,000	5,000,000,000	3.1-5 тэрбум		-	-
5.1-8 тэрбум		-	-	5.1-8 тэрбум		-	-
8.1-10 тэрбум	2 100%	9,000,000,000	18,000,000,000	8.1-10 тэрбум		-	-
>10.1 тэрбум	2 100%	10,000,000,000	20,000,000,000	>10.1 тэрбум		-	-
Нийт		39,300,000,000	78,600,000,000	Нийт		4,470,000,000	8,940,000,000

6.5 Засгийн газрын байгууллагуудад олгосон дэмжлэгийн ач холбогдол


Засгийн газраас шийдвэрлэсэн НДШ-ийн хөнгөлөлтийг (Зураг 25) тур операторуудын 28 хувь нь үр дүн муу, 27 хувь нь үр дүн сайн, 23 хувь нь үр дүн дунд гэжээ. Нийт байгууллагын 22 хувь нь НДШ-ийн хөнгөлөлтөд хамрагдаагүй нь нэг бол НДШ төлдөггүй эсвэл мэдээллээс хоцорсон байж болох юм.

Ажиллагсдад олгосон 200,000 төгрөгийн буцалтгүй тусламжийн талаар 26 хувь нь үр дүн сайтай, 24 хувь нь дунд, 20 хувь нь үр дүн муутай гэж үнэлжээ.

Зээлийн эргэн төлөлтийг хойшлуулсан нь 45 хувьд нь хамаарахгүй байгаа нь зээлгүй байгууллагад хамаарахгүй байсныг илтгэхээс гадна зээлтэй компаниудын хувьд үр дүн муу гэсэн үнэлгээ 25 хувь, сайн-16 хувь, дунд-15 хувь байжээ.

Бусад гэж хариулагсдын дунд “2020.04-2020.10 сард НДШ-г бүрэн чөлөөлж байсан нь их дэмтэй байсан. Одоо үүнийг үргэлжлүүлбэл их хэрэгтэй байна”, “Дээрх үр дүн сайн гэсэн 2 үзүүлэлт зөвхөн 2020 оны 7-9 сард хамаарна. Одоо ямар ч дэмжлэггүй байгаа”, “ямар ч дэмжлэг аваагүй” хэмээн хариулжээ.

Зураг 25. Засгийн газрын дэмжлэгийг үнэлсэн байдал




Үүнээс дүгнэхэд НДШ-ийн хөнгөлөлт, 200,000 төгрөгийн цалингийн татаас болон зээлийн эргэн төлөлтийг хойшлуулсантай харьцуулахад арай илүү үр дүнтэй байгаа байдал ажиглагдаж байна.

Судалгаанд оролцогсдоор (118 компани) Засгийн газраас хэрэгтэй байгаа дэмжлэгийг (Зураг 26) эрэмбэлүүлэхэд 71 хувь нь хөнгөлөлттэй урт хугацааны зээлд хамруулах нь маш чухал, 65 хувь нь нийгмийн даатгалын шимтгэлийг тэглэх нь маш чухал, 64.6 хувь нь ажиллагсдад цалингийн дэмжлэг (татаас) олгох нь маш чухал 63 хувь нь татварын хөнгөлөлт, чөлөөлөлт маш чухал гэж хариулжээ.

Хэдий тийм ч дотоодын аялагчдад зориулсан тур оператор байгууллагаар үйлчлүүлэх ваучерийг 68 хувь, зээлийн төлөлтийг хойшлуулах/царцаахыг 75 хувь, зээлийн хүүгийн татаас олгохыг 77 хувь, цахим сурталчилгааны санхүүгийн дэмжлэгийг 78 хувь нь чухал болон маш чухал хэмээсэн нь эдгээр зүйлс бүгд тур оператор байгууллагад шаардлагатай дэмжлэгүүд болох нь харагдаж байна.

Зураг 26. Засгийн газраас тур операторуудад хэрэгтэй байгаа дэмжлэг



7. ЦАР ТАХЛЫН ДАРАА АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫГ СЭРГЭЭХЭД ШААРДЛАГАТАЙ ЗҮЙЛС

7.1 Засгийн газраас авах бодлого, арга хэмжээ үр нөлөөний шинжилгээ

Аялал жуулчлалын салбарын гол орлого манай улсад ирэх жуулчдын тооноос шууд хамааралтай учир Ковид-19-ийн энэ онцгой нөхцөл байдал дуусах үед аялал жуулчлалын салбарыг аль болох богино хугацаанд сэргээхийн тулд төрөөс ямар бодлого арга хэмжээ авч хэрэгжүүлэх нь оновчтой эсэхийг урьдчилан судалж дүгнэх нь зүйтэй юм. Жуулчдын аялах сонирхол, зан байдал Ковид-19-өөс үүдэлтэй нэлээдгүй өөрчлөгдөж эхэлсэн учир манай улсад жуулчлах сонирхолтой голлох зах зээлд анхаарлаа хандуулан тэдний хувьд нэн тэргүүний тавигдах шаардлагыг судалж үүнд нийцүүлэн уян хатан бодлого боловсруулах хэрэгтэй юм.

“Journal of Tourism Management Research” сэтгүүлийн 2020 оны 7 дугаарт нийтлэгдсэн өгүүлэлд (Amina & Said, July 21, 2020) нийт 308 аялагчдаас тэдний аялах хүсэл сонирхол, зан байдалд Ковид-19 ямар өөрчлөлт бий болгосон талаар судалсан байна. Судалгааны үр дүнгээс харахад тэдний хувьд аялах газрын аюулгүй байдал, болзошгүй эрсдэлээс хэрхэн хамгаалагдсан байх орчин нөхцөл хэрхэн бүрдсэн эсэх нь тэдний аяллын шийдвэр гаргалтад хамгийн чухал гэж үзсэн байна. Тийм ч учраас тэд бүлгээр буюу олноор аялахаас илүүтэй машинаар аялах, ариун цэвэрт тавигдах шаардлагыг маш ихээр чухалчлан аль болох эко-аялалд анхаарлаа хандуулж эхэлсэн байна. Тус судалгааны үр дүнг Хүснэгт 8-д харуулав.

Хүснэгт 8. Ковид-19-ийн жуулчдын аялах шийдвэр гаргалтад нөлөөлж буй хүчин зүйлс

	Таамаглал шалгах	Ангилал	Үр дүн	Статистик ач холбогдолтой эсэх
Ha Аяллын эцсийн цэг эхлэл цэгт ойрхон байх эсэх	Ho	Чухал биш	76.62%	Ач холбогдолтой
	H1	Чухал	23.58%	
Hb Олонд танигдаагүй, цөөхөн жуулчин очих газрыг сонгох	Ho	Чухал биш	48.37%	Ач холбогдолтой
	H1	Чухал	51.62%	
Hc Групп аяллаас татгалзах / круиз, автобус/	Ho	Чухал биш	38.96%	Ач холбогдолтой
	H1	Чухал	61.04%	
Ha Аялах газрын ариун цэврийн нөхцөл байдлыг шалгах (ариутгал, цэвэрлэгээ)	Ho	Чухал биш	26.62%	Ач холбогдолтой
	H1	Чухал	73.38%	
He Аялах газрын эрүүл мэндийн системийн чанарын талаарх мэдээлэл авах	Ho	Чухал биш	33.44%	Ач холбогдолтой
	H1	Чухал	66.56%	
Hf Аяллын даатгалаа няхуур, зөв сонгох	Ho	Чухал биш	31.82%	Ач холбогдолтой
	H1	Чухал	68.18%	

Эх сурвалж: The Impact of Covid-19 on Tourist Consumption Behaviour: A Perspective Article (Amina & Said, July 21, 2020)

Уг судалгаанаас харахад жуулчид аялах шийдвэр гаргалтад аялах газрын ариун цэврийн нөхцөл байдал (ариутгал, цэвэрлэгээ) 73.38 хувь, тухайн аяллын даатгал /магадгүй эрүүл мэндийн тодорхой үйлчилгээг үнэ төлбөргүй даатгалд хамруулах/ 68.18 хувь, тухайн аялах газрын эрүүл мэндийн системийн чанар, тогтолцооны талаарх мэдээлэл 66.56 хувь, аялал олон хүнийг хамрахгүй байх нь

51.62 хувиар тус тус чухал гэдгийг онцолсон байна. Харин тухайн аялах улс хол зайнд байх эсэх тийм ч чухал биш буюу 23.58 хувийг эзэлж байна. Иймд бид заавал ойрын зайн жуулчинд анхаарал хандуулах бус дээрх чухал гэсэн үзүүлэлтэд нэн тэргүүний ээлжид анхаарах нь зохистой юм.

Манай улсын хувьд 2019 оны Монголбанкны судалгаанд (www.mongolbank.mn, хууд. 17) жуулчдаас авсан сэтгэл ханамжийн талаар асуусан асуултад **ариун цэврийн өрөө бохир, олдоцгүй байдал** нь хамгийн их хүндрэлтэй санагдсан гэжээ. Үүнээс гадна **гэр баазын ариун цэврийн байдал, цагаан хэрэглэл, халуун ус хүртээмжгүй хангалтгүй** байгааг дурдсан байна. Иймд энэ асуудлыг зөвхөн тухайн тур оператор, бизнесийнхэн өөрсдөө хөрөнгө оруулах хэлбэрээр дангаараа шийдэх ёстой гэж үзэлгүйгээр үүнд төрөөс бодлогоор дэмжлэг үзүүлэх нь нэн чухал юм. Мөн манай судалгааны хүрээнд тур операторуудаас авсан санал асуулгаар Засгийн газраас дараах арга хэмжээ авах нь чухал гэсэн хариултыг өгсөн байна (Хүснэгт 9).

Хүснэгт 9. Монгол улсад үйл ажиллагаа явуулж буй тур операторуудаас авсан судалгааны үр дүн

№	ЗГ-аас хэрэгжүүлэх бодлого	Ангилал	Үр дүн	Ач холбогдол
1.	Хилээ нээх хугацааг зарлах	Маш чухал	79%	Хамтран ажилладаг байгууллагын итгэлийг алдахгүй байх
2.	Вакцинжуулалт	Маш чухал	77%	Монгол улсад аялахад аюулгүй гэдэг итгэл бий болох
3.	Аяллын үеийн халдвар хамгаалал	Маш чухал	69%	Аяллын үеийн халдвар хамгааллын дэглэмийн нэгдсэн зааварчилгаа гаргах нь жуулчдад аяллын таатай нөхцөл бүрдүүлэх
4.	Сурталчилгааны контент	Маш чухал	66%	Монголын байгаль, соёл уламжлалаар эко-аялал гэсэн ойлголтыг төрүүлэх контент бүтээх, сурталчлах
5.	Дэд бүтэц, аяллын таатай нөхцөл	Маш чухал	16 тур оператор	Ариун цэвэр, халуун ус, ариутгал, цэвэрлэгээний стандартыг хангуулж нөхцөлийг сайжруулах

Эх сурвалж: Судалгааны багийн асуулга -2020, 12 сар

Дээрх судалгааны үр дүнд үндэслэн дүгнэлт хийхэд жуулчдыг ирүүлэх, тэдний тоог нэмэгдүүлэхэд дараах арга хэмжээ чухал ач холбогдолтой гэж үзэж байна. Үүнд:

1. Ариун цэвэр, орчны хамгаалалтыг сайжруулах - 73.38 хувь
2. Аяллын даатгал - 68.18 хувь
3. Эрүүл мэндийн даатгал, үйлчилгээ - 66.56 хувь
4. Мэдээлэл хүргэх, суртал ухуулах, сурталчилгаа /ЗГ-аас дэмжлэг татаас үзүүлэх – 66 хувь
5. Цөөн тооны жуулчдын аяллыг зохион байгуулах /Тур операторуудын маркетинг/ 61.04 хувьтай байна.

Эдгээрээс 5 дахь үзүүлэлтийн хувьд тур операторуудын жуулчдад санал болгох бүтээгдэхүүний багц, үнэ маркетингтай холбоотой учир магадгүй байгууллагууд энэ тал дээр санаачлагатай ажиллах шаардлагатай байна. Харин эхний 4 үзүүлэлтийн хувьд аялал жуулчлалын салбарт үүсээд байгаа нөхцөл байдлыг даван туулах, эрсдэлийг бууруулах гол хүчин зүйл гэж үзэн үүнийг манай улсын

хувьд засгийн газраас авч хэрэгжүүлэх нэн тэргүүний арга хэмжээ гэвэл уг дээрх арга хэмжээг авч хэрэгжүүлснээр эдийн засагт үзүүлэх нөлөөллийг сценарио шинжилгээгээр тодорхойлов.

7.2 Аялал жуулчлалын салбарыг сэргээхэд хэрэгжүүлэх бодлого, арга хэмжээний үзүүлэх нөлөөллийн сценарио шинжилгээ

Орц-гарцын загварын орц, гарцын үржүүлэгчийг тооцсоноор эдийн засгийн ямар нэгэн салбарт гарсан өөрчлөлт бусад эдийн засгийн салбартаа хэрхэн нөлөөлж байгаа болон салбар хоорондын уялдаа холбоог харах боломжтойгоос гадна тухайн салбарт Засгийн газраас авч хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрийн үр дүнг тооцож болдог давуу талтай юм. Аялал жуулчлалын салбарын эдийн засагт үзүүлэх нөлөөллийг Салбар хоорондын тэнцэл буюу Орц-гарцын загварыг ашиглаж 2015 онд Маркетметрикс ХХК³⁰ (2015) тооцож байсан байна. Харин Ковид-19-ийн үед аялал жуулчлалын салбарт үүсээд байгаа эрсдэл хэрхэн Канад улсын эдийн засагт нөлөөлж байгааг энэхүү загвараар, 2016 оны салбар хоорондын тэнцэл ашиглан тооцоолж, богино хугацаанд салбарыг сэргээхэд ямар бодлого илүү чухал нөлөөтэй эсэхийг тодорхойлсон байна (Liu, 2020). Иймд, энэхүү судалгааны хүрээнд мөн аялал жуулчлалын салбарт Засгийн газраас авч хэрэгжүүлэх арга хэмжээний эдийн засагт үзүүлэх нөлөө, аялал жуулчлалын салбар өөрөө дэд салбартаа хэрхэн дэмжлэг болохыг Үндэсний тооцооны 2018³¹ оны Салбар хоорондын тэнцэл дээр үндэслэж (www.1212.mn) сценарио шинжилгээ хийж тооцлоо.

Хүснэгт 10. Судалгааны төсөөлөл

Төсөөлөл	Ариун цэвэр, орчны хамгаалалтыг сайжруулах 73.38%	Аяллын даатгал 68.18 %	Эрүүл мэндийн даатгал, үйлчилгээ 66.56 %	Мэдээлэл хүргэх, суртал ухуулах, сурталчилгаа 66 %	Жуулчдын ирэх магадлалын хувь
Сценари 1: Төрөөс 1 арга хэмжээг авч хэрэгжүүлнэ	*				30%
Сценари 2: Төрөөс 2 арга хэмжээ авч хэрэгжүүлнэ	*			*	50%
Сценари 3: Төрөөс 3 арга хэмжээ авч хэрэгжүүлнэ	*	*		*	80%
Сценари 4: Төрөөс 4 арга хэмжээ авч хэрэгжүүлнэ	*	*	*	*	100%

³¹ 2019 оны салбар хоорондын тэнцэл 2021 оны 2 дугаар сарын 15-нд тархаагдана. Гэхдээ орц, гарцын үржүүлэгчийн хувьд эдийн засгийн бүтэц тогтмол буюу 2021,2022 онд төдийлөн өөрчлөлт орохгүй гэж үзсэн.

Хүснэгт 2-т тооцсон жуулчдын тоог ашиглан сценарио бүрээр 2021, 2022 онд төрөөс авч хэрэгжүүлэх арга хэмжээнээс шалтгаалан ирэх магадлалын хувийг тооцож, улмаар эдийн засагт орж ирэх орлогын төсөөллийг гаргалаа. Засгийн газраас аялал жуулчны байгууллагуудын ариун цэвэр, орчны хамгааллыг сайжруулах чиглэлээр ажиллавал 2021 онд 2019 оны жуулчдын 30 хувийг буюу 192.61 мянган жуулчин хүлээн авах магадлалтай, аяллын даатгал, эрүүл мэндийн даатгалын үйлчилгээг дэмжвэл 2019 оны жуулчдын 80 хүртэлх хувийг (521.63 мянган жуулчин) татах магадлалтай хэмээн таамаглаж байна (Хүснэгт 11).

Хүснэгт 11. Сценарио шинжилгээний өгөгдлийн тооцоо

Төсөөлөл	Жуулчдын тоо, мян.хүн		Эдийн засагт орох орлогын хэмжээ, тэрбум төгрөг	
	2021	2022	2021	2022
Сценарио 1: Жуулчдын 30 хувь	192.61	204.76	411.60	462.28
Сценарио 2: Жуулчдын 50 хувь	321.02	341.26	686.01	770.47
Сценарио 3: Жуулчдын 80 хувь	513.63	546.02	1,097.61	1,232.76
Сценарио 4: Жуулчдын 100 хувь	642.04	682.52	1,372.01	1,540.94

2018 оны 20х20 бүхий салбар хоорондын тэнцлийг Орц-гарцын загварыг ашиглан үйлдвэрлэлийн үржүүлэгчийг тооцоолж, Засгийн газрын зүгээс авах арга хэмжээний 4 хувилбар төсөөллийг нийт эдийн засагт ямар нөлөө үзүүлэхийг тооцъё. Үүний тулд Орц-гарцын загварын үр дүнгийн нэгтгэлийг Хүснэгт 12-т харуулав.

Хүснэгт 12. 2018 оны Салбар хоорондын тэнцлийн үйлдвэрлэлийн үржүүлэгчийн тооцооллын үр дүнгийн нэгтгэл

Салбар	Салбар хоорондын 2018 оны тэнцлийн үйлдвэрлэлийн үржүүлэгч				
	Анхдагч нөлөө	Шууд нөлөө	Шууд бус нөлөө	Үйлдвэрлэлийг дэмжсэн үр нөлөө	Үйлдвэрлэгчийн энгийн үржүүлэгч
1 Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	1.0000	0.0956	0.2317	0.3274	1.3274
2 Уул уурхай, олборлолт	1.0000	0.0331	0.3609	0.3940	1.3940
3 Боловсруулах үйлдвэрлэл	1.0000	0.1080	0.6362	0.7442	1.7442
4 Цахилгаан, хий, уур, агааржуулалтын хангамж	1.0000	0.5999	0.3272	0.9271	1.9271
5 Усан хангамж; бохир ус, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа	1.0000	0.0916	0.6939	0.7855	1.7855
6 Барилга	1.0000	0.0315	0.5617	0.5932	1.5932
7 Бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар, үйлчилгээ	1.0000	0.0478	0.3779	0.4257	1.4257
8 Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	1.0000	0.0811	0.2950	0.3761	1.3761
9 Байр, сууц болон хоол хүнсээр үйлчлэх үйл ажиллагаа	1.0000	0.0073	0.7357	0.7430	1.7430
10 Мэдээлэл, холбоо	1.0000	0.1104	0.4520	0.5625	1.5625
11 Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	1.0000	0.0450	0.2901	0.3351	1.3351
12 Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	1.0000	0.0116	0.2673	0.2789	1.2789
13 Мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	1.0000	0.0775	0.5245	0.6020	1.6020

14	Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	1.0000	0.0660	0.6652	0.7312	1.7312
15	Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал	1.0000	0.0012	0.3416	0.3428	1.3428
16	Боловсрол	1.0000	0.0092	0.3169	0.3261	1.3261
17	Хүний эрүүл мэнд ба нийгмийн үйл ажиллагаа	1.0000	0.0420	0.3284	0.3704	1.3704
18	Урлаг, үзвэр, тоглоом, наадам	1.0000	0.0171	0.4316	0.4487	1.4487
19	Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	1.0000	0.0244	0.7771	0.8016	1.8016
20	Бусад үйл ажиллагаа	1.0000	0.0000	0.0000	0.0000	1.0000

Үйлдвэрлэлийн үржүүлэгч нь тухайн салбарын нэмэлт 1 төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн эрэлтийг хангахын тулд бүх салбаруудаас шаардагдах бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн хэмжээг шууд болон шууд бус нөлөөг харуулдаг. Өөрөөр хэлбэл, шууд нөлөө гэдэг нь жишээлбэл, 18-р салбар буюу Урлаг, үзвэр, тоглоом, наадам гэсэн салбарт 1 төгрөгийн эрэлт үүслээ гэхэд тухайн салбартаа үзүүлэх анхдагч нөлөө нь шууд 1 төгрөг, өөрийн салбартаа үзүүлэх нөлөө 0.0171 төгрөг, харин бусад эдийн засгийн дэд салбарт бий болгох эрэлт буюу шууд бус нөлөө нь 0.4316 төгрөг, харин нийт эдийн засгийн үйлдвэрлэлд үзүүлэх нөлөө 0.4487 болох ба эцсийн дүндээ тус салбарын 1 төгрөгийн эрэлт нийт эдийн засагт 1.4487 төгрөгийн үйлдвэрлэлийг бий болгоно гэж үздэг. Тухайн салбарын үйлдвэрлэлийн үржүүлэгч өндөр байх нь уг салбарын эдийн засаг дахь нөлөө өндөр байгааг илтгэж байна.

Тооцооллыг хийхийн тулд Монгол улсад ирж буй нэг жуулчны оруулж буй орлогын хуваарилалтыг мөн тооцож үзвэл дараах байдлаар хуваарилагдаж байна (Хүснэгт 13).

Хүснэгт 13. Нэг жуулчны зардлын задаргаа

Салбар	Монголбанк судалгааны зардлын тооцоо, ам.доллар	Дэд салбарт хуваарилагдах хэмжээ, хувь %	Судлаачийн тооцоо, ам.доллар	1 жуулчны зардлын задаргаа, төгрөг 1\$=3021.93₮
Орон байр	400	24.1%	494.1	1,493,103.17
Хоол, хүнс	246	14.8%	303.9	918,258.45
Үзвэр үйлчилгээ	272	16.4%	336.0	1,015,310.16
Худалдаа	319	19.2%	394.0	1,190,749.78
Тээвэр	421	25.4%	520.0	1,571,491.09
Нийт	1,658	100%	2,048	6,188,912.64

Эндээс, нэг жуулчны эдийн засагт оруулж буй хувь нэмрийг Салбар хоорондын тэнцлийн үйлдвэрлэлийн үржүүлэгчийг ашиглан тооцож үзлээ (Хүснэгт 14).

Хүснэгт 14. Нэг жуулчны Монголд улсын эдийн засагт үзүүлэх нөлөөллийн тооцоо

Салбар	Салбар хоорондын 2018 оны тэнцлийн үйлдвэрлэлийн үржүүлэгч					
	Анхдагч нөлөө	Шууд нөлөө	Шууд нөлөө	бус	Үйлдвэрлэлийг дэмжсэн нөлөө	Үйлдвэрлэгчийн энгийн үржүүлэгч
9 Байр, сууц болон хоол хүнсээр үйлчлэх үйл ажиллагаа	1,493,103.17	10,861.16	1,098,545.54		1,109,406.70	2,602,509.87
19 Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	918,258.45	22,438.52	713,611.99		736,050.51	1,654,308.96
18 Урлаг, үзвэр, тоглоом, наадам	1,015,310.16	17,396.46	438,208.78		455,605.24	1,470,915.40
7 Бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар, үйлчилгээ	1,190,749.78	56,917.99	449,932.83		506,850.82	1,697,600.60
8 Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	1,571,491.09	127,482.63	463,594.76		591,077.39	2,162,568.47
Нийт	6,188,912.64	235,096.76	3,163,893.90		3,398,990.66	9,587,903.30

Энэ үр дүнг ашиглан Хүснэгт 14-т хийсэн жуулчдын оруулах орлогод суурилан 2021, 2022 оны эдийн засагт үзүүлэх макро түвшний орлогын төсөөллийг тооцоолж гаргалаа (Хүснэгт 15).

Хүснэгт 15. Засгийн газраас авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үндсэн дээр жуулчдын тоо, түүний эдийн засагт үзүүлэх сценари шинжилгээний үр дүн

	Жуулчдын тоо, мян.хүн		Нийт эдийн засагт үзүүлэх орлогын хэмжээ, тэрбум төгрөг		
	2021	2022	2021	2022	
Сценари 1:					
Жуулчдын хувь	30	192.61	204.76	1,846.75	1,963.19
Сценари 2:					
Жуулчдын хувь	50	321.02	341.26	3,077.91	3,271.99
Сценари 3:					
Жуулчдын хувь	80	513.63	546.02	4,924.66	5,235.18
Сценари 4:					
Жуулчдын хувь	100	642.04	682.52	6,155.83	6,543.98

Үүнээс харахад Ковид-19-ийн дараа Засгийн газар ямар арга хэмжээг авч хэрэгжүүлснээс шалтгаалан 2021, 2022 онд Монгол улсад ирэх жуулчдын тоо шууд хамаарах магадлалтай ба эдийн засагт үзүүлэх нөлөөллийг тооцоолох боломжтой байна. Иймд Засгийн газар бодлогоор жуулчдын тоог аль түвшинд хүргэж нэмэгдүүлэх нөөц боломжтой гэдгээ /аль арга хэмжээг авч хэрэгжүүлэх/ нөхцөл байдлын судалгаанд нарийвчилсан дүгнэлт хийж тодорхойлох нь зүйтэй юм.

Аялал жуулчлалын салбарын борлуулалтын орлогын энэ задаргааг ашиглан 2019 онд аялал жуулчлалын салбарын үзүүлсэн нөлөөллийг 2018 оны салбар

хоорондын үйлдвэрлэлийн үржүүлэгчийг ашиглан тооцоолоход дараах үр дүн гарлаа. Ингэхдээ Хүснэгт 9-д авч үзсэн эдийн засгийн 5 салбартаа дэд салбарын орлогын хуваарилсан байдлыг Хүснэгт 16-д үзүүллээ.

Хүснэгт 16. 2020 оны тур операторуудын борлуулалтын орлогоос бусад салбарт хуваарилагдсан байдал

Салбар	Тур операторын 2019 оны түүвэр судалгааны аялал жуулчлалын дэд салбарын ангилал	Тур операторуудын 2019 оны нийт борлуулалтын орлогын дэд салбарт хуваарилагдсан байдал, сая.төг		
9	Байр, сууц болон хоол хүнсээр үйлчлэх үйл ажиллагаа	Малчин айл (хоноглох, морь түрээслэх г.м)	5,372.9	39,866.4
		Зочид буудал	11,125.9	
		Гэр бааз	13,198.5	
		Хоол, Ундаа	10,169.1	
19	Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	Даатгал	1,797.7	7,953.5
		Бусад	6,155.9	
18	Урлаг, үзвэр, тоглоом, наадам	Соёл, спорт, хурал зөвлөгөөний арга хэмжээ	2,522.6	2,522.6
7	Бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар, үйлчилгээ	Аяллын тоног хэрэгсэл	4,534.4	4,534.4
8	Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	Дотоодын тээвэр (агаар, авто, төмөр, усан замын тээвэр)	12,294.9	12,294.9
Нийт			67,171.9	


2019 онд судалгаанд оролцсон тур операторуудын борлуулалтын орлогод үндэслэж 2018 оны салбар хоорондын тэнцлийн үйлдвэрлэгчийн үржүүлэгчийг ашиглан шинжлэхэд эдгээр тур операторууд нь 131.7 тэрбумын орлогоосоо 51 орчим хувь буюу 67.1 тэрбум төгрөгийг аялал жуулчлалын дэд салбартаа шууд хуваарилж чаддаг ба энэ хуваарилалтын эрэлт нь эдийн засгийн нийт үйлдвэрлэлийг 110.8 тэрбум хүртэл өсгөх чадвартай ба хувиар тооцвол 65 хувийн ашигтай гэдэг нь аялал жуулчлалын салбар нь өөрөө түүхий эд шаардахгүй нэмэгдэл өртөг өндөртэй цэвэр ашиг ихтэй эдийн засагт чухал ач холбогдолтой гэдэг нь шууд харагдаж байна (Хүснэгт 16).

Хүснэгт 17. 2019 оны тур операторуудын борлуулалтын орлогын эдийн засгийн үржвэр нөлөө

Салбар	Салбар хоорондын 2018 оны тэнцлийн үйлдвэрлэлийн үржүүлэгчээр 2019 оны судалгаанд оролцсон тур операторуудын эдийн засагт үзүүлсэн нөлөөлөл, сая.төгрөг					
	Анхдагч нөлөө	Шууд нөлөө	Шууд бус нөлөө	Үйлдвэрлэлийг дэмжсэн нөлөө	Үйлдвэрлэгчийн энгийн үржүүлэгч	
9	Байр, сууц болон хоол хүнсээр үйлчлэх үйл ажиллагаа	39,866.4	290.0	29,331.6	29,621.6	69,488.0
19	Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	7,953.5	194.4	6,181.0	6,375.3	14,328.8
18	Урлаг, үзвэр, тоглоом, наадам	2,522.6	43.2	1,088.8	1,132.0	3,654.6
7	Бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар, үйлчилгээ	4,534.4	216.7	1,713.4	1,930.1	6,464.5
8	Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	12,294.9	997.4	3,627.0	4,624.4	16,919.3
НИЙТ		67,171.86	1,741.71	41,941.69	43,683.40	110,855.26

Засгийн газраас аялал жуулчлалыг цаашид сэргээхэд ойрын хугацаанд (2021-2022) хийх шаардлагатай үйл ажиллагааг эрэмбэлүүлэхэд 79 хувь нь жуулчдад хилээ нээх хугацаагаа зарлах нь, 77 хувь нь вакцинжуулалт, 72 хувь нь салбарын хүний нөөцийг хадгалах бодлого явуулах нь маш чухал байна гэж хариулжээ. Мөн 69 хувь нь аяллын үеийн халдвар хамгааллын дэглэмийн нэгдсэн зааварчилгаа гаргах, 65 хувь нь цахим виз олгох, 62 хувь нь эхний жуулчин хүлээж авах орнуудыг зарлах, 66 хувь нь Монгол улсыг сурталчилсан контент дэмжих, санхүүжүүлэх нь маш чухал гэжээ (Зураг 27).

Зураг 27. Засгийн газраас аялал жуулчлалыг цаашид сэргээхэд хийж болох зүйлс




Засгийн газраас өөр ямар үйл ажиллагаа явуулж дэмжиж болох талаарх нээлттэй асуултад 119 компани хариулсан байна. Энэ дунд хөнгөлөлттэй зээл шаардлагатай байгааг онцолж бичсэн 37, сурталчилгааг дурдсан нь 23, нислэгийн үнэ бууруулах тухай дурдсан 16, татварын хөнгөлөлт дурдсан 15, хил нээхийг дурдсан 9, боловсон ариун цэврийн байгууламж байгуулахыг дурдсан 10, аялал жуулчлалын салбарын цогц бодлогыг явуулах тухай дурдсан 8, виз олгох журмыг хялбарчлах, чөлөөлөх ба цахим виз олгохыг дурдсан 7, зам тавих болон сайжруулах 4 санал иржээ. Мөн тодорхой байдал хэрэгтэй байна, нислэгийн хуваарийг жилийн өмнө гаргаж байх шаардлагатай байна, байгаль орчноо хамгаалах шаардлагатай байна зэрэг саналууд мөн гарсан байна.

7.3 Тур операторуудын аялал захиалгын төлөв (2021-2023)

Ойрын 3 жил хүртэлх хугацааны (2021-2023 он) төлөв байдлыг дараах хэсэгт өгүүлэх бөгөөд 109 инбаунд, 13 аутбаунд, 5 дотоодын аяллын компани хариулснаас зөвхөн инбаунд тур операторын мэдээллийг энд орууллаа (Зураг 28). Аутбаунд болон дотоодын аяллын компани хэт цөөхөн байсан тул энэ хэсэгт мэдээлсэнгүй.

2021 онд: Хэдий цар тахлын хөл хорионд байгаа ч нийт (n=111) инбаунд тур операторын талаас илүү буюу 57 хувь нь аяллын захиалгатай байна. Тэдгээр байгууллагын 49 хувь нь цөөн тооны захиалгатай байгаа бол 5 хувь нь цар тахлын өмнөхтэй ойролцоо тооны аяллын захиалгатай байгааг дурджээ. Харин огт захиалгагүй тур оператор 44 хувийг эзэлж байна.

Зураг 28. Инбаунд тур операторын аяллын захиалга (2021-2023)



2022 онд: Тур операторуудын талаас илүү хувь (51%) нь захиалгагүй байна. Харин 46 хувь нь захиалгатай байгаа нь нөхцөл байдал бүр дордоогүйг илтгэж байна. Үүнээс 36 хувь нь цөөн тооны захиалгатай бол 2-6 хувь нь цар тахлын өмнөх түвшний болон олон, маш олон захиалгатай гэсэн байна.

2023 онд: Нөхцөл байдал тодорхойгүй байгаа ч аялал жуулчлалын салбарын онцлог болох урьдчилсан захиалга тодорхой хэмжээгээр хийгджээ. Байгууллагуудын 37 хувь нь аяллын захиалгатай бол олон тооны болон маш олон тооны захиалгын хэмжээ өмнөх 2 жилээс огцом нэмэгдэж 11 хувьтай байна. Энэ нь 2023 оноос аялал жуулчлалын захиалга өмнөх 2 жилтэй харьцуулахад 2 дахин нэмэгдэх төлөвтэйг харуулж байна.

7.4 Засгийн газраас хийх боломжит ажлууд

2020 оны 3-р сард нийтлэгдсэн “Төрөөс аялал жуулчлалыг хөгжүүлэх талаар баримтлах бодлого”-д аялал жуулчлалын салбарын олон улсад өрсөлдөх чадварын үзүүлэлтээр 102 дугаар байранд байгааг 85-р байранд хүргэх, 2022 онд 1.2 сая жуулчин, 2026 онд 1.7 сая жуулчин авна гэсэн зорилтууд тавьжээ. Эдгээр зорилтуудад хүрэхийн тулд: 1) аялал жуулчлалын салбарын эрх зүйн орчинг боловсронгуй болгох, 2) аялал жуулчлалын дэд бүтцийг хөгжүүлэх, 3) гадаад сурталчилгааг эрчимжүүлэх, 4) аялал жуулчлалын бүс нутгийг төрөлжүүлэн хөгжүүлж, эрүүл ахуй, үйлчилгээний чанар, стандартыг сайжруулах,

ажлын байрыг нэмэгдүүлэх, 5) аялал жуулчлалын боловсрол, сургалт, судалгаа, эрдэм шинжилгээний ажлыг хөгжүүлж, хүний нөөцийн ур чадварыг сайжруулах, 6) цахим аялал жуулчлалыг хөгжүүлэх гэсэн зургаан чиглэл гаргажээ. Эдгээр ажил нь дунд хугацаандаа чухал боловч богино хугацаандаа буюу цар тахлын үед тур оператор компаниудаа дампуурлаас хамгаалж, хүний нөөцийг хадгалж авч үлдэхэд нь дэмжлэг үзүүлэхгүй бол аялал жуулчлалын салбар дахин сэргэхэд нэн хэцүү болоод байгааг судалгаанд оролцогсад онцолж байна.

Судалгаанд оролцсон компаниудын (уг асуултад хариулсан 138 компанийн хувьд) 47.1 хувь нь сүүлийн 3 сарын ашиглалтын зардлаа төлөөгүй, 43.5 хувь нь зээлтэй бөгөөд зээлтэй байгууллагуудын 71 хувь нь сүүлийн 6 сард зээлээ төлж чадаагүй гэж хариулснаас харахад нөхцөл байдал хүнд байгааг харж болно. Байгууллагуудын 98 хувь нь ажиллагсдынхаа цалинг бууруулж, цалингүй чөлөө олгож байгаа бөгөөд цалинжуулж байгаа хэсгийн 50 хувь нь цаашид ажиллагсдынхаа цалинг олгох боломжгүй байгаагаас аялал жуулчлалын салбарт ажилгүйдэл, цаашлаад хүний нөөцийн хомсдол үүсэх эрсдэл буй болсныг харж болно. Тиймээс Ковидын нөлөөллийг бууруулах богино хугацааны бодлого, Ковидын дараа аялал жуулчлалыг сэргээх дунд хугацааны бодлого шаардлагатай нь харагдаж байна.

7.4.1 Богино хугацааны бодлого

- Санхүүжилтийн хүрээнд

- Хөнгөлөлттэй зээл

Судалгаанд оролцсон компаниудын 71 хувь нь хөнгөлөлттэй зээл маш чухал гэж хариулсан байв (уг асуултад хариулсан 118). Мөн зээлийн эргэн төлөлтийг хойшлуулах нь хэр үр дүнтэй вэ гэсэн асуултад дээрх компаниудын 45 хувь нь банкинд өр зээлгүй, харин өр зээлтэй компаниудын 26 хувь нь зээлийн эргэн төлөлтийг хойшлуулахыг үр дүн муутай, 15 хувь нь дунд, 16 хувь нь үр дүнтэй гэж хариулсан байснаас харахад хэдийгээр зээлийн эргэн төлөлтийг хойшлуулах нь нэмэртэй байгаа ч үр дүнтэй арга хэмжээ байж чадахгүй байна. Учир нь орлогогүй байгаа энэ үед цалин, урсгал зардлын дарамтын хажуугаар өндөр хүүтэй зээлийн дарамт хүндрэлийг учруулж байгаа тул бага хүүтэй зээл нь энэ салбарыг аврах нэг чухал гарц байж болох юм. Олон улсад мөн хөнгөлөлттэй зээлийг олгосон байна. Жишээлбэл, Шинэ Зеланд тур операторуудад орлогынх нь хэмжээнээс шалтгаалж, 3 хувийн хүүтэй 5 жилийн хугацаатай зээл олгосон байгаа нь Монгол улсад хэрэгжүүлж болох жишээ юм.

- НДШ-ийн хөнгөлөлт

2020 оны 4-10 сард засгийн газраас НДШ хөнгөлөлт үзүүлснийг санал асуулгад оролцогчдын (n=127) 27 хувь нь үр дүн сайн, 23 хувь нь үр дунд, 28 хувь нь үр дүн муу гэж үнэлсэн. Харин НДШ-ийг тэглэх нь маш чухал гэж асуулгад оролцогчдын (n=118) 65 хувь, чухал, 24 хувь нь чухал гэж хариулснаас дүгнэхэд үр дүн муу гэж хариулсны шалтгаан нь зөвхөн 4-10 сартай холбоотой хариулсан байх магадлалтай харагдаж байна.

- Ажиллагсад цалингийн дэмжлэг олгох

Байгууллагуудын 98 хувь (n=134) нь ажиллагсдынхаа цалинг бууруулж, цалингүй чөлөө олгож байгаа бөгөөд ажиллагсдаа цалинжуулж байгаа хэсгийн 50 хувь нь цаашид ажиллагсдынхаа цалинг тавих боломжгүй гэж хариулсан. Ажиллагсдад олгосон 200,000 төгрөгийн буцалтгүй тусламжийн талаар 26 хувь нь үр дүн сайтай, 24 хувь нь дунд, 20 хувь нь үр дүн муутай гэж үнэлсэн байсан боловч Засгийн газраас шаардлагатай байгаа тусламжийг эрэмбэлэхэд ажиллагсдад цалингийн дэмжлэг олгохыг маш чухал гэж үзсэн нь 65 хувь (n=118) байв. Тиймээс ажлын байр хадгалахад шаардлагатай санхүүгийн дэмжлэгийг гурван сараас дээш хугацаагаар олгох нь үр дүнтэй байхаар байна. Тур оператор байгууллагын ажиллагсдын тоог нийт орлогод нь харьцуулбал 1 хүн нэг жилд 12.9 сая төгрөгийн орлого Монгол улсын эдийн засагт оруулж байна. Иймд нэг ажилтанд жилийн 2,400,000 тэтгэмж олгоход их биш дэмжлэг болох нь харагдаж байна.

- Татварын хөнгөлөлт, чөлөөлөлт

Татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийг маш чухал гэж үзсэн нь асуулгад оролцогчдын 63 хувь байв. Ялангуяа орлогогүй бүтэн жил гаруй байсны дараа татварын хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлбэл аялал жуулчлалын салбар сэргэхэд дэмтэй байхаар байна. Хэрэв орлогогүй компани төрөл бүрийн татварын дарамтад орвол татвар төлөгчдийн тоо цөөрөх эрсдэлтэй байна.

- Жуулчин татах чиглэлээр

- Хилээ нээх хугацааг зарлах

Аялал жуулчлалыг сэргээхийн тулд Засгийн газраас ойрын хугацаанд хийх шаардлагатай ажлууд дундаас хамгийн олон байгууллага чухал гэж үзсэн ажил бол жуулчдад хилээ нээх хугацааг зарлах (79 хувь нь маш чухал, 16 хувь чухал, n=119) гэж хариулжээ. Учир нь хэзээнээс захиалга авч болох талаар мэдэх боломжгүй байгаа тул хүндрэл учруулж байна гэж тур операторууд үзжээ. Тиймээс нөхцөл байдлыг сайн, дунд, муу гэсэн сценариар үнэлж, жуулчдад хилээ нээх хамгийн цаад хугацааг зарлавал аялал жуулчлалын компаниудын үйл ажиллагаа сэргэхэд чухал нөлөөтэй байх болно. Аяллын захиалга хийхэд гадны түнш байгууллага жуулчдын хүсэл сонирхлыг асууж, Монгол дахь жуулчны байгууллагатай харилцаж, цаг их шаардлагатай байдаг тул сул зогсолтын энэ үед хил нээх үеийн захиалгаа авч байвал өгөөжтэй байх болно. Жуулчдад хилээ нээхдээ Шинэ Зеланд, Тайвань шиг шат дараалалтай нээж болно. Үүнд Ковидын эрсдэл багатай улсуудад хилээ нээх, мөн вакцинд хамрагдсан жуулчдад хилээ нээх, хил дээр түргэвчилсэн шинжилгээ авах зэргээр арга хэмжээ авч болох юм. Үүнд оролцогсдын 62 хувь нь жуулчин эхэлж хүлээж авах орнуудыг зарлах нь маш чухал байна гэж хариулсан байв. Ялангуяа шууд нислэгтэй улсуудтай аяллын ногоон гарц нээх нь оновчтой хувилбар байж болохоор байна.

- Вакцинжуулалт

Вакцинжуулалт маш чухал гэж оролцогсдын 77 хувь хариулсан бөгөөд вакцинжуулалт хийж эхлэх үед олон улсад Монгол улс вакцинжуулалт хийж байгаа талаар мэдээлэх нь чухал. Мөн Ковидыг дотооддоо барьсан үед түүнийгээ сурталчилж, манайд аялахад аюулгүй гэж олон улсад сурталчлах нь чухал гэжээ.

Гэсэн хэдий ч судалгаа гүйцэтгэж байх үе болон түүнээс хойших цар тахлын нөхцөл байдал Монгол улсыг эрсдэлгүй бүс гэх урьдны төсөөллийг өөрчилж байгааг анхаарах нь чухал байна.

- Аяллын үеийн халдвар хамгаалал

Аяллын үеийн халдвар хамгааллын дэглэмийн нэгдсэн зааварчилгаа гаргах нь маш чухал гэж оролцогсдын 69 хувь үзсэн бөгөөд нэгдсэн зааварчилгаа гаргах, мөн халдвар хамгааллын дүрмийг сайтар сахиулснаар жуулчдыг татаж, аюулгүй аялуулах боломжтой гэсэн санал хэлжээ. Ялангуяа халдвараас сэргийлэх, халдвар гарсан үеийн салбар хоорондын уялдаа холбоо хийгээд салбарын хүний нөөцийг вакцинжуулах, орон нутгийн иргэдэд үнэн зөв мэдээллийг түгээх нь аяллын үеийн халдвар хамгааллын нөхцлийг хангахад ач холбогдолтой байхаар байна.

7.4.2 Дунд хугацааны бодлого, арга хэмжээ

- Сурталчилгааны контент

Монгол улсыг сурталчилсан контент хийж олон улсад түгээх нь чухал гэж оролцогсдын 66 хувь үзжээ. Мөн санал бичих хэсэгт 23 оролцогч сурталчилгааг онцолсон байв. Тухайлбал, сүүлийн хэдэн жил Хү хамтлагийн уран бүтээл маш том сурталчилгаа болж байгааг ашиглах, мөн олон улсын томоохон телевизийн сувгуудтай хамтарч Монголын байгаль, соёл уламжлалаар контент бүтээвэл өгөөжтэй байх төлөв ажиглагдаж байна.

Өнгөрсөн хугацаанд буюу 2019 онд тур оператор байгууллагууд 6,831.25 сая төгрөгийг маркетингт зарцуулсан бөгөөд 2020 онд энэ хэмжээний сурталчилгааны зардлын үр дүн цар тахлын улмаас гарсангүй. Харин БОАЖЯ олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнгийн санхүүжилтэд 2017 онд 41.2 сая төгрөг, 2018 онд 150 сая төгрөгийг зарцуулжээ. Тур оператор байгууллагууд 2018 онд 2019 онтой ойролцоо хэмжээний сурталчилгааны зардал гаргасан хэмээн үзвэл 2019 онд Монголд жуулчилсан 577,300 жуулчны 52 хувьд үйлчилсэн тур операторууд 1 жуулчинг татах сурталчилгаанд 22,185 төг (9 ам доллар) зарцуулсан байна.

- Дэд бүтэц

Монголд ирэх нислэгийн үнийг бууруулах шаардлагатай гэж 16 оролцогч онцгойлон бичсэн байсан бөгөөд үнэхээр ч Монголд ирэх нислэгийн үнэ өндөр байдаг тул жуулчдын тоо нэмэгдэхэд саад болдог аж. Мөн боловсон ариун цэврийн байгууламжийг онцгойлж бичсэн 10 оролцогч байсан бөгөөд Монголд ирээд хөдөөгөөр аялсан жуулчид хамгийн хэцүү асуудлын нэгд тооцогддог гэжээ.

- Виз

Виз олгох журмыг хялбарчлах, цахимаар олгох зэрэг нь жуулчны визний асуудлыг хүндрэл багатайгаар шийдвэрлэхэд нэн чухал байна. Монголтой ойролцоо Төв Азийн улсуудын жишээнээс үүнийг бэлхнээ харж болно. Виз олголт хялбар

болсноор голлох зах зээлээс ирж буй жуулчинд чирэгдэл багатай, шуурхай үйлчилж, аялах сэдэлд нэгэн түлхэц болох болно.

8. СУДАЛГААНЫ ДҮГНЭЛТ

- Уг судалгаагаар аялал жуулчлалын салбарт цар тахлаас үүдсэн макро болон микро (байгууллагуудын) түвшний хүндрэл, бэрхшээл, мөнгөн алдагдал, засгийн газраас явуулсан арга хэмжээний үр нөлөө, цаашид юу хийх шаардлагатай талаар судаллаа.
- Судалгаанд нийт 252 тур оператор хамрагдаж цар тахал тэдний бизнесийн үйл ажиллагаанд хэрхэн нөлөөлж байгаа талаар хариулжээ. Эдгээр байгууллагууд олон жилийн ажлын туршлагатай, мэргэжлийн байгууллагууд байна.
- Монгол улсын инбаунд жуулчдын тоо сүүлийн 10 жилд харьцангуй жигд өсөлттэй байж 2019 онд 577.3 мянгад хүрч байсан бол Ковид-19-ийн үед буюу 2020 онд энэ тоо даруй 89.8 хувиар буурч 58.9 мянга болсон байна. Үүний 62 хувь нь 2020 оны эхний улиралд зочилсон байв.
- Макро түвшинд цар тахлаас улбаалсан аялал жуулчлалын салбарын алдагдал 2020 он гэхэд 1.2 их наяд төгрөг, энэ байдал 2021-2022 онд үргэлжилнэ гэж тооцвол нийтдээ 4.13 их наяд төгрөгийн орлогыг алдах магадлалтай байна.
- Судалгаанд хамрагдсан байгууллагуудын хувьд хамгийн гол таван зах зээлд АНУ, Герман, Франц, Их Британи, Өмнөд Солонгос орж байгаа бол удаах таван гол зах зээлд Австрали, Япон, Швейцар, Итали, БНХАУ улс тооцогдож байна. Өөрөөр хэлбэл Англи хэлтэй зах зээл хамгийн гол зах зээл байгаа бол үүний дараагаар Герман, Франц хэлтэй зээх зээл удаалжээ. Азиас Хятад, Солонгос, Япон хэлтэй зах зээл хамгийн чухалд тооцогджээ.
- Эдгээр байгууллагуудын талаас илүү нь түүх соёл, нутгийн иргэдэд түшиглэсэн аялал, морин аяллыг зохион байгуулж байна. Тусгай сонирхлын аялал жуулчлалаас хамгийн түгээмэл нь фото аялал болон уулын аялал байгаа бөгөөд тур операторуудын 22.3 хувь болон 20.3 хувь нь тус тус эдгээр төрлийн аяллыг зохион байгуулж байна. Нийт жуулчны тоог тоймлоход түүвэрт хамрагдсан 117 байгууллага 2019 онд 65,200-80,300 жуулчин хүлээж авчээ. Энэ нь тухайн жилд Монгол улсад ирсэн жуулчдын 14 хувьтай тэнцэж байна.
- Судалгаанд хамрагдсан байгууллагын 141 (55.7%) нь 2019 онд Үндэсний эдийн засагт 131.7 тэрбум төгрөгийн орлого оруулсан байна. Ойроцоогоор 10.1 мянган хүн 215 тур операторт байнгын болон улирлын ажил эрхэлж байжээ. Үүнээс хамгийн олон нь жолооч 3,727, хөтөч 3,646 оффис ажилтан 1,364 байна.

Цар тахлын үеийн хүндрэлийг даван туулж буй байдал

- Нийт (n133) тур операторын 56 хувь нь үйл ажиллагаагаа түр зогсоосон, 15 хувь нь бүр мөсөн зогсоосон байна. Харилцагчдын захиалгаа хойшлуулсан 39 хувь, дотоодын аяллын зах зээлд ажилласан 20 хувь байна.
- Тур операторуудын 88.1 хувийнх нь борлуулалтын орлого 91-100 хувь буурсан байна. Ажиллагсдаа цомхотгосон 54.8 хувь байгаа бол тэдний 62.7 хувь нь 1-5 ажилтнаа цомхотгожээ.
- Сүүлийн 3 сарын ашиглалтын зардлаа төлөөгүй байгууллага 47.1 хувийг эзэлж байна. Мөн зээлтэй байгууллагууд 43.4 хувийг эзэлж байгаа ч тэдний 71.1 хувь

нь зээлээ төлж чадахгүй байгаагаас нөхцөл байдал хэр хүндэрснийг илтгэж байна.

- Тур операторуудын (n134) 73.1 хувь нь ажиллагсдын цалиндаа өөрчлөлт оруулжээ. Үүнээс давхардсан тоогоор 10 хувь нь л цалингаа 1-30 хувь бууруулсан бол 88 хувь нь 31-100 хувь бууруулжээ. Ажиллагсдаа цалинжуулахгүй, НДШ-ийг төлж байгаа байгууллага 20 хувийг эзэлж байна.
- Нийт (n137) тур операторын 50 хувь нь 2020 оны 12 сард ажиллагсдаа цаашид цалинжуулах боломжгүй гэсэн бол үүнээс хойш 6 сарын дараа буюу 2021 оны 6 сар гэхэд нийт тур операторын 84% нь буюу 10 компани тутмын 8 нь ажиллагсдаа цалинжуулах боломжгүй болохоор байна.
- Цар тахлын үеийг давах хөрөнгийн эх үүсвэр давхардсан тоогоор дараах байдалтай байна. Хуримтлагдсан ашигаар-39%, төрөл бүрийн зээлийн эх үүсвэрээр бүрдүүлж байгаагаас найз нөхдийн зээл- 34%, банкны зээл-20%, гадаад түншийн зээл-17% байна. Аяллын урьдчилгаа төлбөрөөр-32% нь цар тахлын үеийн хүндрэлтэй нөхцөл байдлыг даван туулж байна. Мөн бусад бизнесийн орлогоо ашиглаж буй нь 24%-ийг бүрдүүлж байна. Нийт тур операторын дөнгөж 17% нь эрсдлийн сантай байгаа нь бусад тур операторуудад эрсдэлийн сантай байхын ач холбогдлыг сануулж буй сайн туршлага болж байна.
- Үйл ажиллагаагаа түр зогсоосон 71 байгууллагад 1,619 ажиллагсад, бүр мөсөн зогсоосон 19 байгууллагад 260 ажиллагсад ногдож байна. Эдгээр байгууллагууд 2020 онд ойролцоогоор 43.7-87.5 тэрбум төгрөгийн орлого олох боломжоо цар тахлаас сэргийлж, хил хаагдсаны улмаас алджээ.

Засгийн газрын дэмжлэгийг үнэлсэн байдал

- НДШ-ийн хөнгөлөлтийг 53 хувь нь дундаас дээш үр дүнтэй байсан гэжээ. Харин ажиллагсдад олгосон 200,000 төгрөгийн дэмжлэгийг 50 хувь нь үр дүн дундаас дээш хэмээн үнэлсэн бол 30% нь хамрагдаж чадаагүй байна.
- Зээлийн эргэн төлөлтийг хойшлуулсныг дөнгөж 31 хувь нь дундаас дээш үр дүнтэй арга хэмжээ гэжээ.

Засгийн газраас хүсч буй дэмжлэг

- Засгийн газрын зүгээс хийх шаардлагатай зүйлсийг эрэмбэлүүлэхэд дараах таван зүйлсийг 63-71 хувь нь маш чухал гэж хариулжээ. Хаалтанд илэрхийлсэн жигнэсэн дундаж үнэлгээ ч эдгээрийг хамгийн чухал таван арга хэмжээ гэдгийг илтгэж байна. Үүнд:
 1. Хөнгөлөлттэй урт хугацааны зээл (2.63)
 2. Ажиллагсдад цалингийн дэмжлэг олгох (2.6)
 3. Нийгмийн даатгалыг тэглэх (2.55)
 4. Татварын хөнгөлөлт, чөлөөлөлт (2.52)
 5. Ажиллагсдын цалингийн зээлийн төлөлтийг хойшлуулах/царцаах (2.34).

Аялал жуулчлалыг сэргээхэд авах арга хэмжээ

- Тур операторуудын хувьд 2021-2023 онд 44-56 хувь нь тодорхой хэмжээний аяллын захиалгатай байгаа нь аялал жуулчлалын салбар төсөөлснөөс хурдан сэргэх магадлалтайг илтгэж байгаа бөгөөд Засгийн газрын зүгээс

оновчтой бодлого шуурхай явуулах шаардлагатайг илтгэж байна. Тэр дундаа 2021-2022 онд 36-49 хувь нь цөөн захиалгатай, ковидын өмнөх үеийн болон түүнээс олон захиалгатай байгууллагууд 7-19 хувийг бүрдүүлж байна.

- Тур операторуудын 62-79 хувь нь маш чухал гэж үзсэн дараах зүйлсийг засгийн газраас аялал жуулчлалыг сэргээхэд авах арга хэмжээний эхний долоод эрэмбэлжээ. Үүнд:
 1. Олон улсын жуулчин хүлээж авахад хилээ нээж эхлэх боломжит хугацааг зарлах;
 2. Вакцинжуулалт;
 3. Салбарын хүний нөөцийг хадгалах бодлого явуулах;
 4. Аяллын үеийн халдвар хамгааллын дэглэмийн нэгдсэн зааварчилгаа гаргах;
 5. Цахим виз олгох;
 6. Ирээдүйд ирэх жуулчдыг идэвхжүүлэх зорилгоор Монгол орныг сурталчилсан контентийг дэмжих, санхүүжүүлэх;
 7. Эхний жуулчин хүлээн авах орнуудыг зарлах.
- Судалгаанд хамрагдсан тур операторууд 131.7 тэрбумын орлогоосоо 51 орчим хувь буюу 67.1 тэрбум төгрөгийг аялал жуулчлалын дэд салбартаа шууд хуваарилж чаддаг ба энэ хуваарилтын эрэлт нь эдийн засгийн нийт үйлдвэрлэлийг 110.8 тэрбум хүртэл өсгөх чадвартай ба хувиар тооцвол 65 хувийн ашигтай гэдэг нь аялал жуулчлалын салбар нь өөрөө түүхий эд шаардахгүй нэмэгдэл өртөг өндөртэй цэвэр ашиг ихтэй эдийн засагт чухал ач холбогдолтой гэдэг нь харагдаж байна.
- Олон улсын судалгаанаас харахад жуулчид аялах шийдвэрт аялах газрын ариун цэврийн нөхцөл байдал (ариутгал, цэвэрлэгээ) 73.38 хувь, тухайн аяллын даатгал /магадгүй эрүүл мэндийн тодорхой үйлчилгээг үнэ төлбөргүй даатгалд хамруулах/ 68.18 хувь, тухайн аялах газрын эрүүл мэндийн системийн чанар, тогтолцооны талаарх мэдээлэл 66.56 хувь, аялал олон хүнийг хамрахгүй байх нь 51.62 хувиар тус тус чухал гэдгийг онцолсон байна. Харин тухайн аялах улс хол зайнд байх эсэх тийм ч чухал биш буюу 23.58 хувийг эзэлж байна.
- Иймд уг судалгаагаар тоймлосон нөхцөл байдлын (сценарио) шинжилгээгээр Монгол улсын Засгийн газраас сценари 1-сценари 4-т дурдсан арга хэмжээг хэрэгжүүлбэл олон улсын аялал жуулчлал цар тахлын өмнөх хэмжээнд хүртэл сэргэх магадлалтай ба хамгийн бага төсөөллөөр инбаунд аялал жуулчлал 2019 оны тооны 30 хувь хүртэл сэргэхэд 411.6 тэрбум төгрөг, 80 хувь сэргэхэд 1,097.61 тэрбум төгрөгийн орлого олох магадлалтай байна.
- Тур оператор байгууллагын ажиллагсдын тоог нийт орлогод нь харьцуулбал 1 хүн нэг жилд 12.9 сая төгрөгийн орлого Монгол улсын эдийн засагт оруулж байна. Иймд нэг ажилтанд жилийн 2,400,000 тэтгэмж олгоход (200,000 төгрөгөөр тооцвол) их биш дэмжлэг болох нь харагдаж байна.
- Орлогогүй бүтэн жил гаруй байсны дараа татварын хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлбэл аялал жуулчлалын салбар сэргэхэд дэмтэй байхаар байна. Хэрэв орлогогүй компани төрөл бүрийн татварын дарамтад орвол татвар төлөгчдийн тоо цөөрөх эрсдэлийг дагуулж байна.
- Тур оператор байгууллагууд Ковид-19 цар тахлын үед өөрсдөөс хамаарах, байж болох бүх арга хэмжээг 2020 оны туршид авч байгаа бөгөөд 2021 оны 6 сар гэхэд нийт тур операторын 88 хувь нь ажиллагсдаа цалинжуулах

боломгүй хэмжээнд тулж ирж байгаа нь Засгийн газраас ямар нэг дорвитой арга хэмжээ яаралтай авч, аялал жуулчлалын салбарын мэргэшсэн хүний нөөцөө хадгалахад анхаарах хэрэгтэй болсныг харуулж байна.

Эх сурвалж

Монгол

Амартүвшин.Д., Гантуяа.Н., Энхжаргал.Д, ба Оюунчимэг.Л. (2020) *Дотоодын аялагчид аялал жуулчлалын салбарыг аврах уу.* [цахим] http://mongolia-tourism-research.blogspot.com/2020/05/blog-post_22.html.

Монголын Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим (МХАҮТ) (2020) Монголын Бизнесийн орчин 2020: судалгааны тайлан. [цахим] <https://www.mongolchamber.mn/resource/mongolchamber/File/2020/12/03/xuopjkh69by6gsqr/Business-sudalгаа-2020.pdf>.

Монголын Аялал Жуулчлалын Холбоо (2020) *Уулзалтын тэмдэглэл.* Улаанбаатар

Монголбанк ба Аялал жуулчлалын хөгжлийн төв (2019). *Аялал жуулчлалын салбарын өнөөгийн байдал, шийдвэрлэх асуудлууд түүвэр судалгааны үр дүн.* [цахим] https://www.mongolbank.mn/documents/sudalгаа/Survey%20results_web.pdf

Үндэсний Статистикийн Хороо (ҮСХ) (2020). *Монгол улсын худалдаа, үйлчилгээний салбарын танилцуулга 2019.* Улаанбаатар.

Маркетметрикс (2015). *Аялал жуулчлалын салбарын Улаанбаатар хотын эдийн засагт үзүүлэх нөлөө.* Улаанбаатар: Нийслэлийн засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Аялал жуулчлалын газар.[цахим]<http://tourism.ub.gov.mn/wp-content/uploads/2015/11/Economic-Impact-of-Tourism-UB.pdf>

Эрүүл Мэндийн Яам (2020). "Ковид-19 Коронавирус Гэж Юу Вэ?" Эрүүл Мэндийн Яам, [цахим] <https://www.mohs.mn/v/232>.

Ikon.mn (2020). "Гуравдугаар сарын 2-ныг дуустал Монгол Улсын иргэдийг урд хөрш рүү явахыг хориглолоо." <https://ikon.mn/n/1s93>.

Ikon.mn (2021). "Цар тахлын нөлөөг бууруулахад улсын төсвөөс 2021 онд 1.7 их наяд төгрөг зарцуулагдахаар байна." <https://ikon.mn/n/248o>.

News.mn (2020). "УОК: Цэцэрлэг, сургуулийг гуравдугаар сарын 2-н хүртэл хаана." <https://news.mn/r/2252974/>.

Эрдэнэчимэг, Э. and М. Мөнхдулам (2020). "Цар тахлын үед Монгол Улсын Засгийн газраас эдийн засгаа сэргээх, мөнгө болон санхүүгийн бодлогын хүрээнд авсан арга хэмжээ." <https://www.kas.de/mn/web/mongolei/einzeltitel/-/content/t-rijn-bajguulal-sudlal-setg-l-02>.

Эрүүл мэндийн яам (2021). "2021 оны 03 дугаар сарын 27 өдрийн нөхцөл байдлын мэдээ." <https://covid19.mohs.mn/p/cat/post/57/>.

Англи

Australian Government (2020), The Treasury. "Economic Response to the Coronavirus." [Online] <https://treasury.gov.au/coronavirus>.

Baker, M.G., Wilson, N. and Blakely, T., 2020. Elimination could be the optimal response strategy for covid-19 and other emerging pandemic diseases. *bmj*, 371.

Bremmer, Ian. (2020) "The Best Global Responses to Covid-19 Pandemic." TIME, [Online] <https://time.com/5851633/best-global-responses-covid-19/>.

Brookings.(2020) "Learning from the Best: Evaluating Africa's Covid-19 Responses." [Online] <https://www.brookings.edu/blog/africa-in-focus/2020/07/08/learning-from-the-best-evaluating-africas-covid-19-responses/>.

Chang, Rachel, Jinshan Hong, and Kevin Varley.(2020) "The Covid Resilience Ranking." Bloomberg,, [Online] <https://www.bloomberg.com/graphics/covid-resilience-ranking/>.

Chebli.A., & Said, F. B. (2020). The Impact of Covid-19 on Tourist Consumption Behaviour : A Perspective Article. *Journal of Tourism Management Research*, 7, 169-207.

Farr, Christina, and Michelle Gao (2020). "How Taiwan Beat the Coronavirus." CNBC, [Online] <https://www.cnbc.com/2020/07/15/how-taiwan-beat-the-coronavirus.html>.

Fisher, D., Teo, Y.Y. and Nabarro, D., 2020. Assessing national performance in response to COVID-19. *The Lancet*, 396(10252), pp.653-655.

Foreign Policy (2020). "The Covid-19 Global Response Index." Foreign Policy, [Online] <https://globalresponseindex.foreignpolicy.com/>.

Government of Kenya, Ministry of Tourism and Wildlife (2020). "Covid-19 and Travel and Tourism in Kenya Policy Brief." [Online] <https://www.tourism.go.ke/wp-content/uploads/2020/10/COVID-19-AND-TRAVEL-AND-TOURISM-IN-KENYA-POLICY-BRIEF.pdf>.

Liu, H. (2020). *The Economic Impact of Travel Restrictions on the Canadian Economy due to the COVID-19 Pandemic*. Authority of the Minister responsible for Statistics Canada.

IMF(2020). "World Economic Outlook Update." [Online] <https://www.imf.org/en/Publications/WEO/Issues/2021/01/26/2021-world-economic-outlook-update>.

Ministry of Business, Innovation and Employment (2020). "Tourism Recovery." [Online] <https://www.mbie.govt.nz/immigration-and-tourism/tourism/tourism-recovery/>.

- Ministry of Culture, Sports and Tourism, Republic of Korea (2020). "Korea's Policy Responses to Covid-19: Building Resilience for Culture, Sports and Tourism." [Online] [https://www.k-culture.jp/link_files/Responses%20to%20covid-19%20ROK\(final\).pdf](https://www.k-culture.jp/link_files/Responses%20to%20covid-19%20ROK(final).pdf).
- Robert, A., (2020). Lessons from New Zealand's COVID-19 outbreak response. *The Lancet Public Health*, 5(11), pp.e569-e570.
- Taiwan Centers for Disease Control (2020). "Covid-19 Infection." [Online] <https://www.cdc.gov.tw/En>.
- Tyce, Matthew (2020). "Kenya's Response to Covid-19." Effective States and Inclusive Development, [Online] <https://www.effective-states.org/kenyas-response-to-covid-19/>.
- UNWTO (2020). "2020: Worst Year in Tourism History with 1 Billion Fewer International Arrivals " [Online] <https://www.unwto.org/news/2020-worst-year-in-tourism-history-with-1-billion-fewer-international-arrivals>.
- Wang, C.J., Ng, C.Y. and Brook, R.H., (2020). Response to COVID-19 in Taiwan: big data analytics, new technology, and proactive testing. *Jama*, 323(14), pp.1341-1342.
- WHO (2020). "Who Coronavirus Disease (Covid-19) Dashboard." WHO, [Online] <https://covid19.who.int/>.
- WTTC (2020). "Latest Research from Wttc Shows a 50% Increase in Jobs at Risk in Travel & Tourism." [Online] <https://wttc.org/News-Article/Latest-research-from-WTTC-shows-a-50-percentage-increase-in-jobs-at-risk-in-Travel-and-Tourism>.

